

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА****2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр, Мягмар гараг****Хуралдааны тэмдэглэлийн агуулга****Хуралдааны товч тэмдэглэл:** 1-3**Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:** 4-37

**1. Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай
хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон
хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн
газар 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх
эсэх/** 4-37

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны
04 дүгээр сарын 22-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 29 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баттулга, Б.Заяабал, М.Нарантуяа-Нара, С.Одонтуяа, Б.Пүрэвдорж;

Чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Э.Бат-Амгалан, Д.Ганбат, У.Отгонбаяр.

Нэг.Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, Нийтийн эрх зүйн хэлтсийн шинжээч О.Мандах, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, мөн газрын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдал хангах албаны дарга Н.Лхагвасайхан, мөн албаны Олон нийтийн аюулгүй байдлыг хангах хэлтсийн ахлах байцаагч Б.Бодьгэрэл, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Ажиллагааны хэлтсийн дарга С.Лхагвадорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн дарга Ц.Батбаатар, мөн хэлтсийн ахлах зөвлөх Г.Агар-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ч.Батбямба, А.Болортуяа, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Улсын Их Хурлын Тамгын газраас гаргасан хууль зүйн дүгнэлтийг Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур нар танилцуулав.

Илтгэл болон дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, Х.Баасанжаргал, Ц.Сандаг-Очир, О.Номинчимэг, Б.Энхбаяр, С.Эрдэнэболд, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

байдал хангах албаны дарга Н.Лхагвасайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Г.Агар-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Л.Соронзонболд, Х.Баасанжаргал, Б.Энхбаяр, С.Эрдэнэболд, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: 1.Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Дайны байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 12 гишүүнээс 9 гишүүн дэмжиж, 75.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Дотоодын цэргийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

5.Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 47 минут үргэлжилж, ирвэл зохих 22 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 59.1 хувийн ирцтэйгээр 17 цаг 16 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
15 цаг 29 минут.

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Д.Цогтбаатар: Байнгын хорооныхоо гишүүдэд энэ өдрийн мэнд дэвшүүлье. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Ирц 54.5 хувьтай байна. Ингээд Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдаанд ирсэн ирц ирцэд орсон гишүүдийг танилцуулъя.

Дамдины Цогтбаатар, Норовын Алтанхуяг, Хүрэлбаатарын Баасанжаргал, Одсүрэнгийн Номинчимэг, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Гончигдоржийн Уянгахишиг, Даваагийн Цогтбаатар, Баттөмөрийн Энхбаяр, Сүхбаатарын Эрдэнэболд гэсэн гишүүд хүрэлцэн ирснээр ирц 54.5 хувьтайгаар бүрдээд байна.

Ингээд ирцийг танилцуулж дууслаа. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлаа танилцуулъя. Өнөөдөр 1 асуудал байгаа.

Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн. Өнөөдөр хэлэлцэх эсэхийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу? Саналаа өгье.

Байхгүй байна. Хэлэлцэх асуудлаа тэгвэл баталлаа. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, хэлэлцэх эсэх асуудал.

Засгийн газраас 1 дүгээр сарын 23-ны өдөр, энэ оны 2025 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн байгаа Улсын Их Хуралд.

Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаарх хэлэлцүүлгийг явуулъя.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Оюунсайханы Алтангэрэл танилцуулна. Алтангэрэл сайдын микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлын 35 дугаар тогтоол, Засгийн газрын 2024-өөс 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 1994 онд батлагдсан Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр танилцуулж байна.

Тус хуулийн төслийг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, Монгол Улсад хүний эрхийн төлөв байдлын нийт 6 удаагийн илтгэлд тусгасан мэдээлэл, дүгнэлт, зөвлөмж, хуулийн хэрэгжилтийн талаар Эмнести Интернэшнл ТББ-аас гаргасан тайлан, дүгнэлт, зөвлөмж, Монгол Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооноос 2021 онд зохион байгуулсан Жагсаал, цуглаан зохион байгуулах журмын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх олон нийтийн хэлэлцүүлэгт тусгагдсан зарим асуудлууд үндэслэн нэрийг Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн төсөл гэж өөрчлөн дараах агуулгаар боловсруулаад байна. Үүнд:

Нэгдүгээрт, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд жагсаал, цуглааныг Монгол Улсын иргэн, улсын бүртгэлд бүртгэгдсэн улс төрийн нам, ТББ зохион байгуулах эрхтэй байгааг Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага зохион байгуулах эрхтэй байх байхаар өргөжүүлэх.

2.Хүчин төгөлдөр хуульд жагсаал, цуглаан зохион байгуулах, санаачлах асуудал нь тодорхой хүрээ хязгаартай. Тухайлбал, улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар гэж тусгайлан заасныг өөрчилж, ямар ч асуудлаар жагсаал, цуглаан хийж болохоор нээлттэй байх.

3 дугаарт, Жагсаал, цуглааны төрөл, хэлбэр болох аяндаа бий болсон, зэрэгцсэн, эсрэг жагсаалыг зохион байгуулахыг хүлээн зөвшөөрч, тэдгээрийн аюулгүй байдлыг хангах, хэв журмыг хамгаалах.

4.Бүртгүүлэх нэртэй боловч зөвшөөрөл авдаг тогтолцоог халж, зөвхөн авто замын зорчих хэсэг дээр урьдчилан мэдэгдэж хариу явсны үндсэн дээр хуулиар хориглосноос бусад газар мэдэгдэл хүргүүлснээр зохион байгуулах боломж бүрдүүлэх.

5.Мэдэгдэл хүлээн авах, хариу өгөх, хууль бус жагсаал, цуглааныг албадан тараах эрх бүхий этгээд нь Засаг дарга буюу улс төрийн албан тушаалтан байгааг өөрчилж, мэдэгдэл хүлээн авах этгээд нь Цагдаагийн байгууллага. Харин албадан тараах этгээдийг Цагдаагийн байгууллагын саналыг, албадан тараах этгээдийг Цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн ЗДТГ-ын дарга байхаар өөрчлөх.

6.Хориглолт, хязгаарлалтыг тодорхой болгохоор төсөл зохицуулалтыг тусгасан. Нийгмийн хэв журам, үндэсний аюулгүй байдлыг хангах, бусад хүний эрх, эрх чөлөөг хамгаалах шаардлагаар зөвхөн хуулиар хориглолт, хязгаарлалт

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

тавихыг хүлээн зөвшөөрч жагсаал, цуглаан хийх эрхийг хориглосон, хязгаарласан агуулгатай захиргааны акт баталж, мөрдүүлэхийг хориглох.

7.Зөвхөн хуульд заасан үндэслэлээр албадан тараах. Ингэхдээ тус ажиллагааг баримтжуулах урьдчилан сануулах, оролцогчдын хувийн байдалд тохирсон арга хэмжээ авах, аль болох хамгийн бага хүч хэрэглэх аргыг сонгох, тус ажиллагааг хэрэгжүүлсэн талаар олон нийтэд мэдээлэл өгдөг байх.

Түүнчлэн хуулийн төсөлд хүчин төгөлдөр үйлчилж байгаа зарим зохицуулалтыг хэвээр хадгалсан болно.

Тухайлбал, онц байдал, дайны байдал зарласан, гамшиг осол тохиолдсон хугацаанд хориглох, энэ хууль болон бусад хуулиар хориглох тодорхой байршлууд зохион байгуулагч болон оролцогчийн үүрэг, мэдэгдэл хүргүүлээгүй тохиолдолд Зөрчлийн тухай хууль үйлчлэх, мөн хууль бус жагсаал, цуглаан нь албадан тараах үндэслэл болох зэрэг болно.

Түүнчлэн шөнийн цагаар жагсаал, цуглаан хийхийг хориглох агуулгыг нэмж тусгалаа.

Хуулийн төсөл батлагдсанаар Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактад заасан иргэдийн тайван хуран цуглах эрх хангагдаж, зөвхөн хуульд заасан үндэслэлээр энэхүү эрхийг хязгаарлах зохицуулалт баталгаажна. Жагсаал цуглааны хэлбэрүүдийг хүлээн зөвшөөрнө. Жагсаал цуглааны хориглолт, хязгаарлалтын хүрээ, хязгаар тодорхой болно. Хуульд зааснаас бусад аливаа хэлбэр тухайлбал, захиргааны хэм хэмжээний актаар хязгаарлах боломжгүй болно.

Жагсаал, цуглаан зохион байгуулахад бүртгүүлэх үүрэгтэй эрх бүхий байгууллага бүртгэсэн тохиолдолд жагсаал, цуглаан хийх эрхтэй болох зохицуулалт үйлчилж байгаа байдал хязгаарлагдаж, зөвхөн онцгой нөхцөл байдал, зайлшгүй хориглох цөөн тохиолдлоос бусад тохиолдолд цагдаагийн байгууллагад мэдэгдэл хүргүүлснээр жагсаал, цуглаан зохион байгуулах боломж бүрдэнэ.

Цагдаагийн байгууллагаас олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн дэг журам, нийтийн хэв журмыг сахиулахдаа хүний эрхийн зөрчил гаргахгүй байх, хууль ёсны тайван жагсаал, цуглаанд жагсагч болон цагдаа хамтран ажиллах, хоорондоо идэвхтэй харилцаатай байх, мэдээлэл солилцох, зөвлөн туслах нөхцөл бүрдэнэ.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Дотоодын цэргийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дайны байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг дагалдуулан боловсрууллаа.

Иймд хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг хэлэлцэн дэмжиж өгнө үү.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Д.Цогтбаатар: Алтангэрэл сайдад баярлалаа.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 34.1-д заасны дагуу гаргасан Хууль зүйн дүгнэлтийг Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ариунхур танилцуулна.

Энэ дэгийн тухай шинэ хуулийн дагуу хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу энд автоматаар ингээд Тамгын газраас дүгнэлт гаргадаг болсон байгаа. Ингээд Ариунхур дарга хэддүгээр микрофон, 1 дүгээр микрофон, 1 дүгээр микрофон өгье. Хууль зүйн дүгнэлтийг та бүгдэд тараасан байгаа. Ер нь танилцсан байгаа. Гэхдээ Ариунхур дарга танилцуулъя.

Ч.Ариунхур: Хууль зүйн байнгын хорооны дарга, гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль зүйн дүн шинжилгээний газраас гаргасан хууль зүйн дүгнэлтийг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5.5 дахь заалт Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 36.1 дэх хэсгийг үндэслэн хууль зүйн дүгнэлтийг гаргалаа. Хууль зүйн дүгнэлтийг Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслүүдийн талаар Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 34.1.1-ээс 1.6-д заасан асуудлын хүрээнд гаргасан болно.

1.Төсөл Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, бусад хуульд нийцсэн эсэх, төслийн зүйл заалт, хэсэг хоорондоо зөрчилдсөн эсэх, тухайн төсөл, түүний зарим зүйл, хэсэг, заалтын зохицуулалтын хэрэгжих боломж харилцан уялдааны талаар

1.Төслийн 6.1 дэх хэсэгт Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага тодорхой асуудлаар үзэл бодлоо олон нийтэд, төрийн байгууллагад хүргэх зорилгоор хуулиар хориглоогүй нийтийн эзэмшил болон хувийн өмчийн газарт тайван жагсаал, цуглаан хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулах түүнд оролцох эрхтэй гэж, жагсаал, цуглаан зохион байгуулж болох газрыг заажээ. Манай улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиудад нийтийн эзэмшлийн газар гэх нэр томъёог тодорхойлоогүй бөгөөд үүнд ямар газар хамаарахыг заагаагүй байна. Түүнтэй төсөөтэй ойлголтыг өөр нэр томъёогоор бусад хууль хуульчилсан байна.

Тухайлбал, Газрын тухай хуульд 3.1.9 нийтийн эдэлбэрийн газар гэж зохих журмын дагуу нийтээр ашиглахаар тогтоогдсон төрийн өмчийн газрыг, 12.2 дахь хэсэгт нийтийн эдэлбэрийн газарт, хот тосгон, бусад суурины гудамж талбай, зам, нийтийн амралт зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэгт хүрээлэн, оршуулгын газар, хог хаягдлын цэг, цэвэршүүлэх талбай, авто зогсоол, ногоон байгууламж, нийтээр ашиглах барилга, байгууламжийн газар, дахин өргөжүүлэх төслийн хүрээнд бий болсон нөөц талбай зэрэг хамаарна гэж заажээ. Түүнчлэн 6.1 дэх хэсэгт заасан хувийн өмчлөлийн газар гэх нэр томъёог бусад хуулиудад мөн адил тодорхойлоогүй ба Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

тухай хуульд заасан Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн хувийн өмчийн газарт төсөлд дурдсан хувийн өмчлөлийн газар хамаарахаар ойлгогдож байна.

Монгол Улсын үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт төр нь өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална гээд заасан. Өмчлөгч этгээд жагсаал, цуглааныг өөрийн хувийн өмчийн газартаа зохион байгуулах эсэх нь түүний эрхийн асуудал бөгөөд харин бусдын өмчийн газарт жагсаал, цуглаан зохион байгуулахдаа өмчлөгчөөс зөвшөөрөл авах асуудлыг төслөөр зохицуулаагүй байгааг хэлэлцүүлгийн явцад анхаарах шаардлагатай байна.

Венецийн комиссын эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний талаарх байр суурийн эмхэтгэлд байршил замаа сонгох эрх чөлөөг үл харгалзан тайван жагсаал хийх эрх нь хувийн өмчид шууд нэвтрэх эрхийг олгохгүй. Иргэдийг хувийн өмчийн газар цуглаан хийхээс сэргийлэх тохиолдолд өмчлөгчийн эрхийг тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй заавал харилцан тэнцвэртэй авч үзэх ёстой. Тухайлбал, нийтийн эзэмшлийн газар хүрэлцээгүйн улмаас хувийн өмчийн газарт жагсаал, цуглаан хийхийг зөвшөөрсөн бол өмчлөгчийн эд хөрөнгөө өмчлөх эрхийг дордуулахгүй байх ёстой гэснийг анхаарч, хэлэлцүүлгийн шатад өмчлөгчийн эрхийг хамгаалах зохицуулалтыг хуульд тусгах нь зүйтэй гэж үзэж байна.

Түүнчлэн төсөлд жагсаал, цуглаан зохион байгуулахыг хориглох газар болон жагсаал, цуглаан зохион байгуулж болох газрыг нэгэн зэрэг заажээ. Ингэснээр Газрын тухай хуульд заасан газрын бусад ангилалд хамаарах газарт жагсаал, цуглаан хийж болох эсэх нь тодорхойгүй үлдэж, хууль хэрэглээний ойлгомжгүй байдал үүсгэж болзошгүй байна.

2.Төслийн 10.1 дэх хэсэгт Монгол Улсын хилийн боомт, төрийн ордон, түүний нутаг дэвсгэр, эмнэлгийн байгууллага, нисэх онгоцны буудал, төмөр замын өртөө буудал, хорих анги, түүний хамгаалалтын зурвас, улсын онц чухал объект, түүний хамгаалалтын бүс, төрийн тусгай хамгаалалтын бүс гэсэн 8 газар жагсаал, цуглаан зохион байгуулахыг хоригложээ.

Засгийн газрын 2017 оны 884 дүгээр тогтоолоор цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад авах улсын онц чухал объектын жагсаалтыг батлахдаа 4 ангиллаар нийт 30 объектыг онц чухал объектод хамруулсан байна. Мөн Засгийн газрын 2012 оны 64 дүгээр тогтоолын хавсралтаар төрийн тусгай хамгаалалтад зайлшгүй байх шаардлагатай зүйлийн жагсаалтад 33 объектыг хамруулжээ.

НҮБ-ын хүний эрхийн хорооноос өгсөн 37 дугаар ерөнхий зөвлөмжийн 50 дугаарт тайван цуглааныг зарчмын хувьд нийтийн гудамж талбай гэх мэт олон нийт чөлөөтэй нэвтрэх боломжтой бүх газар хийж болно гэсэн ба тайван жагсаал, цуглаан зохион байгуулахад хууль тогтоомжоор хориглох, газар, байршил, объектыг өргөжүүлэхгүй байх, байршлыг чөлөөтэй сонгох боломжтой байх нь уг эрх чөлөөний мөн чанар болохыг тэмдэглэсэн байна.

Иймд уг объектыг Засгийн газрын тогтоол, шийдвэрээр өргөжүүлэх боломжтой байгааг анхаарна уу хэлэлцүүлгийн явцад. Төслийн 10.4 дэх хэсэгт Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын 21 дүгээр зүйлд заасан агуулгын хязгаарлалтаас өргөн хүрээний хориглолт тусгасныг анхаарах шаардлагатай.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Фактын 21 дүгээр зүйлд тайван хуран цуглах эрхийг хүлээн зөвшөөрнө. Энэхүү эрхийг эдлэхэд ардчилсан нийгэмд буюу үндэсний буюу нийгмийн аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахуун хамгаалах, ёс суртахууныг хамгаалах, эсхүл бусдын эрх чөлөөг хамгаалах эрх ашгийн үүднээс хуулийн дагуу тогтоосноос өөр хязгаарлалт хийж болохгүй гэж заасан. НҮБ-ын Хүний эрхийн хороо иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын 21 дүгээр зүйлийн хүрээнд жагсаал, цуглаанаар илэрхийлэх агуулгыг өргөн хүрээнд хязгаарлах байх. Хуулиар хориглоогүй үзэл бодлыг нийгмийн зарим хэсгийн бухимдал, дургүйцлийг төрүүлэх, цочрохуйц арга хэлбэрээр илэрхийлэхийг тайван гэж үзэж хамгаалах, Засгийн газрын бодлого үйл ажиллагааг шүүмжилсэн улс төрийн шинжтэй тайван жагсаал, цуглааныг онцгойлон хамгаалахыг зөвлөжээ.

Иймд хориглох үндэслэлийг нэгдэн орсон Хүний эрхийн олон улсын гэрээ, Хүний эрхийн Үндэсний Комиссын өгсөн зөвлөмжийн хүрээнд дахин нягтлахыг зөвлөж байна.

4.Төслийн үзэл баримтлалд цагдаагийн байгууллагаас жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний мөн чанар үүссэн зөрчлийг хэлэлцээний аргаар шийдвэрлэх ур чадварыг төлөвшүүлэх, жагсаал, цуглааныг албадан тараахдаа эрх хэмжээг хэтрүүлэхгүй байх, жагсагчтай тохирсон харилцан үүсгэх, дэмжих, хамтрах, зохицуулах, сануулах, тараах, хүч хэрэглэх гэсэн дарааллыг баримтлах шаардлагатай гэж дурдсан ба төслийн 5 дугаар бүлгийн оролцогчийн аюулгүй байдлыг хангах, дэг журмыг хянуулах гэж, хангуулах гэж нэрлэсэн ч төслийн 5 дугаар бүлэгт оролцогчдын аюулгүй байдлыг хэрхэн хангах процессын шинжтэй зохицуулалт дутмаг, дэмжих, хамтрах, зохицуулах, сануулах арга хэмжээний зохицуулалт хангалгүй байгааг анхаарах шаардлагатай.

Тухайлбал, зарим улсын хууль, жагсаал цуглааны хүрээ хязгаарыг баримжаалах үүднээс тусгай тууз татах, хуульд заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд цагдаагийн байгууллагаас эхний ээлжийн жагсаал, цуглааныг сайн дураар тарахыг зөвлөх, жагсагчдад ийнхүү тарах тодорхой хугацаа олох зэрэг зохицуулалт тусгагдсан байдгийг дурдаж байна.

5.Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16 дахь заалт Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын 21 дүгээр зүйлд баталгаажуулсан эрх чөлөө нь тайван замаар хуран цуглах, жагсах үндсэн агуулгыг илэрхийлж байна. Төслийн 15 дугаар зүйлд зохицуулахаар тусгасан өлсгөлөн зарлах асуудал нь үүнд шууд утгаар хамаарахгүй байна.

Хүчин төгөлдөр үйлчилж буй жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 6-д гудамж талбайд өлсгөлөн зарлахыг хөндлөнгөөс зориуд зохион байгуулахыг хүний амь нас, эрүүл мэндийг үл хайхарсан хүмүүнлэг бус үйлдэл гэж үзэж хориглоно гэж заасан байна.

Төслийн 4.1.5-д өлсгөлөн гэсэн нэр томъёог тодорхойлж холбогдох зохицуулалтыг тусгасан нь үүнийг жагсаал, цуглааны нэг бүрэлдэхүүн хэсэг гэх мэтээр ойлгоход хүргэж болзошгүй. Мөн уг тодорхойлолтод нийтийн эзэмшлийн, эсхүл хувийн өмчийн газарт гэж байршлын хязгаарлалт тогтоож, тодорхой төрлийн харилцааг зохицуулсан шинжтэй хэм хэмжээ тусгасан нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 34-тэй, хэсэгтэй уялдуулах шаардлагатай байна.

БНСУ, Польш, Сингапур, Финлянд зэрэг улс орнуудын ижил төрлийн харилцааг зохицуулж буй хуулиудад өлсгөлөн зарлах асуудлыг зохицуулаагүй нь тайван замаар хуран цуглах, жагсах эрх чөлөөний агуулга, мөн чанарыг харгалзан үзсэнтэй холбоотой гэж үзэх үндэслэлтэй.

Иймд хэлэлцүүлгийн шатанд уг асуудлыг анхаарч үзэхийг зөвлөж байна.

6.Хуулийн төслийн нэр томъёоны тодорхойлолтыг тусгасан 4 дүгээр зүйл нь агуулгын болон хууль зүйн техникийн хувьд уялдаагүй зарим асуудал байна.

Тухайлбал, 4.1.1, 4.1.2-т жагсаал, цуглааныг тус тусад нь тодорхойлохдоо тодорхой тооны хүн зохион байгуулж буй үйл ажиллагааг хамааруулсан бол 4.1.3-д тайван жагсаал, цуглааныг тодорхойлохдоо хүнээс гадна хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага зохион байгуулж байгаа үйл ажиллагааг ойлгохоор заасан байна. Төслийн 4.1.4-д хууль бус жагсаал, цуглааныг тодорхойлсон ч Хууль тогтоомжийн тухай хуулийн 30.6 дахь хэсэгт нэр томъёо нэг утга, агуулгаар нийт хуулийн хэл хэмжээнд хэрэглэгдэх бол түүний тодорхойлолтыг уг хуулийн нийтлэг үндэслэл бүлэгт оруулан заана гэсэнтэй нийцэхгүй байна.

Тодруулбал, хууль бус жагсаал, цуглаан гэсэн нэр томъёо уг хуулийн төсөлд дахин хэрэглэгдээгүй ба хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөлд 2 удаа хэрэглэхээр тусгажээ.

Төслийн 3 дугаар бүлгийн 8 дугаар зүйлд эд зүйлийг тайлбарлахдаа зөвхөн гэр, майхан, тээврийн хэрэгсэл, нисгэгчгүй төхөөрөмж, цахилгаан үүсгүүр байхаар тодорхойлсон нь хууль хэрэглээний явцад хязгаарлагдмал байж болзошгүйг анхаарах хэрэгтэй байна.

Төслийн 5 дугаар бүлгийн гарчгийг оролцогчийн аюулгүй байдлыг хангах, дэг журмыг хангуулах гэж нэрлэсний дэг журам журмыг хангуулах гэснийг Цагдаагийн албаны тухай хуульд заасан нэр томъёонд нийцүүлж нийтийн хэв журам хамгаалах гэх зэргээр төслийн зарим нэр томъёог холбогдох хуульд нийцүүлэн томъёолохоор байна.

Мөн Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын 4.1.4.1-т хуулийн нэр томъёоны тодорхойлолт гэсэн гарчигтай зүйл нэр томъёог цагаан толгойн үсгийн дарааллаар байрлуулна гэж заасан шаардлагыг уг төсөлд хангуулах шаардлагатай байна.

2.Хамт өргөн бас мэдүүлсэн хуулийн төслүүд нь төслийн зохицуулалттай уялдсан эсэх, нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа хууль, тогтоолын төсөл нь тухайн хууль, тогтоолын төслийн зорилт, зорилго, үндсэн зарчимтай нийцэж байгаа эсэх талаар, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд тусгайлан өгөх дүгнэлтгүй ба дагаж мөрдөж буй Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.14-д төрийн бодлого, үйл ажиллагааг эсэргүүцсэн аливаа жагсаал, цуглаанд оролцохыг нийт төрийн албан хаагчдын үйл ажиллагаанд хориглосон буюу Төрийн, улс төрийн болон үйлчилгээний албан тушаалд энд хамаарч байгааг хэлэлцүүлэх энэ шатанд анхаарахыг зөвлөж байна.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Төслийг Монгол Улсын нэгдэн орсон Хүний эрхийн олон улсын гэрээ, НҮБ-ын холбогдох гэрээний хорооноос өгсөн зөвлөмжид нийцүүлэн боловсронгуй болгох шаардлагатай байна. Тодруулбал, төсөл нь жагсаал, цуглаан эрх чөлөөний тухай гэсэн нэртэй ч уг эрх чөлөөг хязгаарласан зохицуулалт цөөнгүйг анхаарахыг зөвлөж байна. Хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэх шатанд Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид нийцүүлж, нэр томьёо, хууль зүйн техникийн шаардлагыг хангуулах нь зүйтэй гэж үзлээ.

Дүгнэлтийг танилцууллаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Цогтбаатар: Ариунхур даргад баярлалаа. Ингээд хууль зүйн дүгнэлтийг та бүхэнд тараасан байгаа гэж би түрүүн хэлсэн байгаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Алтангэрэл Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нарантуяа Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Жамъянхүү Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Батзориг Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, Лхагвадорж Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Ажиллагааны хэлтсийн дарга, Гүррагчаа Нийтийн хэв журам хамгаалах олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Олон нийтийн аюулгүй байдлыг хангах хэлтсийн дарга, Лхагвасайхан Цагдаагийн ерөнхий газрын Нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдал хангах албаны дарга, Нийтийн хэв журам хамгаалах олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Олон нийтийн аюулгүй байдлыг хангах хэлтсийн ахлах байцаагч Бодьгэрэл, Монголын өмгөөлөгчдийн холбооны удирдах зөвлөлийн гишүүн Сүхбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Нийтийн эрх зүйн хэлтсийн шинжээч Мандах гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг оролцож байна.

Өшөө энд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн дарга Батбаатар, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Агар-Эрдэнэ гэсэн мэргэжилтэн, албан тушаалтнууд ажлын хэсэгт ирж оролцож байна.

Ингээд төслийн үзэл баримтлалтай холбогдуулан төсөл санаачлагчаас асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү.

Эрдэнэболд гишүүнээр тасаллаа. Уянгахишиг гишүүний микрофоныг өгье. Номинчимэг гишүүн, Алтанхуяг гишүүнийг нэмж оруулаарай.

Г.Уянгахишиг: Энэ өдрийн мэндийг хүргэе. Ер нь энэ хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Өөрөөр хэлэх юм бол Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль байсныг Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн төсөл болгож байгаа. Энэ концепцын хувьд маш том өөрчлөлт. Хэлэлцээд эхлэн, хэлэлцэж байх явцад шинэчилсэн найруулга учраас бас засварууд оруулах, сайжруулах зүйлс нэлээн байгаа гэж харж байгаа. Тэгээд энэнтэй холбоотой яг өнөөдрийн нөхцөл байдалтай холбоотойгоор нэг асуултыг тодруулж асууя гэж бодоод байгаа юм.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Юу гэхээр бид нар энэ Жагсаал, цуглааны тухай хуулиар ер нь улс төрийн шинжтэй жагсаал, цуглааныг зохион байгуулдаг, тэрийг зохицуулж байгаа юм шиг ойлгоод байдаг. Гэтэл энэний цаана бол бас аж ахуйн нэгж, иргэдийн эрхийг зөрчсөн тайван бус жагсаал, цуглаан өөрөөр хэлэх юм бол үзэл бодлоо илэрхийлж байна, чөлөөтэй эрхээ эдэлж байна гэдэг үндэслэлээр аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд садаа учруулдаг, хүний эрхэд халддаг ийм асуудлууд их байдаг. Олон улсдаа бол энэ Жагсаал, цуглааны эрх чөлөөний тухай хууль дээр энэ асуудал бас зохицуулагдсан байх ёстой байдаг.

Тэгэхээр 1 дүгээр асуулт бол энэ хуулиар яг энэ асуудлыг зөвхөн улс төрийн биш тэр хөдөө, орон нутагт гарч байгаа асуудлууд байна, мөн хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн эд хөрөнгөд халдах энэ жагсаал, цуглаан гэдэг нэрийн доор хийж байгаа энэ ажиллагаанууд энэ хуулиар зохицуулагдах уу гэдэг 1 асуулт байна.

Энэ хүрээндээ сая өчигдөр болсон асуудлыг бол та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа. Монгол Улс өнөөдөр гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжинэ гээд гадаадын хөрөнгө оруулагчтай гэрээ байгуулаад зөвшөөрлийг нь өгчихсөн, зөвшөөрлийнхөө дагуу хууль ёсны дагуу үйл ажиллагаагаа эрхлээд явж байгаа тийм аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд, тэр тусмаа бүүр хүний эрхэд, биед халдаж байгаа онц ноцтойгоор халдаж байгаа энэ асуудал ердөөсөө ч хүний эрхийн асуудал биш. Өөрөөр хэлэх юм бол үзэл бодлоо илэрхийлж байна гээд хэн нэгний эрхэд халдаж байгаа асуудал өөрөө энэ Монгол Улсын Үндсэн хуулиар зөвшөөрөгдсөн асуудал биш шүү гэдэг дээр энэ дээр бас хатуу зогсмоор байна.

Тэгээд энэ асуудалд ер нь хууль цагдаагийн байгууллага ямар байдлаар хандаж байна вэ? Тэр гадаадын хөрөнгө оруулагчийн эрхийг хангах тал дээр ямар арга хэмжээ авч ажиллаж байгаа вэ? Энийг бас далимдуулаад асуучихмаар байна.

Д.Цогтбаатар: Сайд хариулах уу? Эсвэл тэр 2 дахь цагдаагаас хариулах уу? Ямар ч гэсэн сайд эхлээд хариулъя.

О.Алтангэрэл: Энэ хуучин хууль дээр улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар жагсаал хийж болно гээд яг тусгайлан заачихсан юм. Тэгээд нийгэм, эдийн засгийн асуудлаар болох нь байна. Хүний эрх чөлөөтэй холбоотой улс төр, нийгэм гээд тэгээд ингэж заасан байсныг бид нар шинэ төслөөрөө ер нь ямар ч асуудлаар хүн жагсаж, цуглаж болно гээд оруулж байгаа. Энийг чинь тодорхойлоод, категорид хуваагаад энэ эдийн засгийнх юм, энэ улс төрийнх юм, энэ болно энэ болохгүй гэх арга байхгүй байгаа юм л даа. Олон улсын зөвлөмж нь ч тэр ерөөсөө ингэж хязгаарлахгүй гээд тэгээд ямар ч асуудлаар ингэж жагсаж болно. Тэгээд энэ чинь хүнийхээ тооноос авхуулаад 2, түүнээс дээш гээд жагсаал, цуглааны хэлбэрүүдтэй нь болно.

Энэ өчигдөр болсон үйл явдалтай холбоотойгоор өнөөдөр бас цагдаагийн байгууллагаас мэдээлэл хийсэн. Тэгэхээр энэ мэдээллийн хүрээнд энэ бусдын эрх, эрх чөлөөнд холдсон этгээдүүдтэй холбоотойгоор зөрчлийн хэрэг нээгээд шалгаж байна гэж ойлгосон. Тэгэхлээр өнөөдөр манай Монгол Улсын хууль тогтоомжоор гадаадын иргэн, харьяалалгүй хүн, Монгол Улсын иргэн ялгалгүйгээр Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомж үйлдэгдэж байгаа нутаг дэвсгэрт эрх, эрх чөлөө нь хамгаалагдах ёстой.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Таны бүүр том хөндөж байгаа агуулгаар Хууль зүй, дотоод хэргийн яамны зүгээс бид ярилцаад энэ төсөл, хөтөлбөрийг гацаадаг, зогсоодог энэ асуудлыг ер нь яах юм бэ гэж хэлэлцээд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргаад яамны веб сайт дээрээ тавьсан юм. Хөгжлийн төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг зогсоох гэдэг нэртэй томьёолол нь. Тэгээд хөгжлийн төсөл, хөтөлбөр гэдэг нь Монгол Улсын Их Хурлаас батлагдсан гэрээ, хэлэлцээрийн дагуу явагдаж байгаа үйл ажиллагааг бид нар ойлгоно гэдэг тодотголтой. Энэ үйл ажиллагааг зориуд санаатайгаар тасалдуулсан бол улс төрд нөлөө бүхий этгээд нь өөр ялтай, бусад этгээдүүд нь өөр хариуцлагатай байхаар ийм зүгээр санал авсан юм. Тэгээд энэ асар их шүүмжлэлтэй тулгарсан. Ингээд шүүмжилсэн хүн болгоныг эрүүлжүүлээ, ял өгөх нь гээд ингээд тэр доор байгаа тайлбар, хөгжлийн бодлого, хөтөлбөр гэдгийг, төсөл, хөтөлбөр гэдгийг юу гэж ойлгох вэ гэснээс үл шалтгаалаад ийм их эсэргүүцэлд орсон.

Тэгэхдээ ер нь яг энэ Монгол Улсын хууль тогтоомжоор буюу нэн ялангуяа Эрүү, Зөрчлийн хуулиар хамгаалагдаж байгаа харилцааг зөрчсөн хэн ч гэсэн энэ үйлдэлдээ хариуцлага хүлээх ёстой гэсэн тийм таны байр суурийг дэмжиж байна.

Д.Цогтбаатар: Болчхож байгаа юу? Тусдаа тийм. Тэгвэл хэн Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: 3 багц асуулт байна. Энэ жагсаал, цуглааныг тараахтай холбоотой шийдвэрийг урьд нь Засаг дарга гаргаж байсан бол одоо Тамгын газрын дарга гээд ингээд төрийн албан хаагч орж ирээд байна. Энэ яагаад ингэж оруулж ирж байгаа вэ гэдэг нэг асуулт.

Дагалдаж орж ирж байгаа хуулиуд жаахан санаа зовж байна. Тэгээд энийг эргэж харахгүй бол ялангуяа Цагдаагийн албаны тухай хууль, Зөрчлийн тухай хууль дээр өмнө нь сум, дүүргийн Засаг даргын шийдвэр гэдэг байсан бол маш ерөнхий болоод эрх бүхий этгээдийн шийдвэр гэгчхэж байгаа юм. Тэгэхээр аягүй ерөнхий болчхож байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ маань өөрөө яг нөгөө хууль зүйн дүгнэлттэй бол бас зарим яг энэ асуудлууд бол энийг анхаарах хэрэгтэй болов уу гэж гэж бодож байна. Тэгэхээр ялангуяа энэ эрх бүхий этгээд гээд тэгээд төрийн албан хаагчийг оруулж ирсэн шалтгааныг тайлбарлаач.

Хоёрдугаарт, энэ хууль бус жагсаал, цуглаан гээд байгаа маань нэр томьёоны тайлбараас гадна Дотоодын цэргийн тухай хууль дээр ороод ирж байгаа. Тэгэхээр энэ чинь өөрөө энэ хуулиас гадна өөр бусад хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд яг энэ дотоодын цэргийн асуудал орж ирж байгаа нь бас их санаа зовохоор ийм заалт орж ирж байна. Тэгэхээр энэ хууль бус жагсаал, цуглаан гэдгийг ер нь ямар агуулгаар энд оруулж ирээд байгаа юм бэ гэдгээ тайлбарлая.

Гуравдугаарт, энэ хуулийн төслийн 13.5.2 дээр хүний эрх, эрх чөлөө, нэр төрийг хамгаалах зорилгод нийцсэн байх ёстой гээд байгаа байхгүй юу. Нөгөө жагсаал маань. Дахиад л нөгөө нийтийн албан тушаалтан, улс төрчдийн ямар нэгэн нэр төр, алдар хүндтэй холбоотой ингээд л эсрэг жагсаал болсон тохиолдолд энэ маань дахиад л зогсоох ёстой, таслан зогсоох ёстой жагсаал, цуглаанд орчхоод байна л даа. Тэгэхээр энэ мэт ийм яг нарийн харвал яг энд жагсаал, цуглаанаа эрх чөлөөг нь илүү нээлттэй болгож байгаа мэт боловч

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

процессын шинжтэй зохицуулалтууд маань өөрөө нэлээн хязгаарлалтууд орж ирээд байна. Тэгэхээр энэ дээр тайлбар авъя.

Би хууль зүйн дүгнэлттэй холбоотой асуулт асууж болно тээ? Хууль зүйн дүгнэлттэй холбоотой энэ маань өөрөө шинэчилсэн найруулга учраас саяын миний хэлсэн саналууд орох боломжтой юу? Тэгээд 40 хувь, 50 хувь, 49 хувьд яах ийх билээ гэдэг дээр буцаах хэмжээний өөрчлөлтүүд байна уу, эсвэл хэлэлцэх эсэхийг нь дэмжээд агуулгын хувьд бас яг энэ зайлшгүй энэ хүний эрхтэй холбоотой хязгаарлалтууд орж ирээд байгаа асуудал дээр бас зайлшгүй ажиллах хэрэгтэй байна л даа. Тэгэхээр энэ саналуудыг оруулах боломж, орон зай одоогийн байгаа төсөл дээр хэр байгаа вэ гэдэг ийм асуултыг асууя.

Д.Цогтбаатар: Алтангэрэл сайд.

О.Алтангэрэл: Жагсаал, цуглааныг албадан тараах шийдвэрийг хэн нэгэн субъект гаргах гээд байгаа юм. Тухайлах юм бол үнэхээр энэ хуулиар заагдсан болон бусад хуулиар хамгаалагдаж байгаа олон нийтийн аюулгүй байдал, иргэдийн амь нас, эрүүл мэнд, аюул учруулбал хэн нэгэн субъект гаргана. Тэгэхээр өнөөдөр тухайн шатны Засаг дарга гэдэг яг цэвэр улс төрийн албан тушаалтан болчихоод байгаа юм. Аль нам ялсан тэр намаас л томилогдсон хүн болчихоод байгаа юм. Тэгээд бид нар энэ Тамгын дарга гэдэг албан тушаалтныг энэ ажлыг хамгийн сайн мэдэх бөгөөд төрийн захиргааны албан тушаалтны яг энэ улс төрийн албан тушаалтантайгаа хамгийн ойр байгаа бөгөөд төрийн захиргааны шийдвэр гаргах энэ төрийн жинхэнэ албан хаагчийн учраас энэ шийдвэр гаргахдаа тухайлах юм бол гадаа хэний нам жагсаж байгаагаас үл шалтгаалаад хэнийг эсэргүүцэх, хэнийг огцор гэж хэлэхээс үл шалтгаалаад өөрөө хариуцлага хүлээдэг төрийн захиргааны жинхэнэ албан хаагчийн хувьд шийдвэр гаргахдаа төрийн улс төрийн албан тушаалтнаасаа илүү хариуцлагатай шийдвэр гаргах болов уу улс төржих нь аливаа арай бага болов уу л гэж бид бодож, ярьж төслийн хүрээнд ингэж сонгож оруулсан юм.

Энэ хууль бус жагсаал, цуглаан гэдэг дээр энэ хуулийн төслийн нэг гол үзэл баримтлал нь хориглосон газар, хориглосон цаг хугацаа, хориглосон зорилго агуулгаар жагсаал, цуглаан хийсэн тохиолдолд хууль бус гэж үзэхээр байгаа. Тэгээд энэ тохиолдолд албадан тараахтай холбоотой зохицуулалт хэрэгжинэ.

Хуулийн төслийн тэр 13.6-д хууль бус гэдгээр хэрэглэгдэж байгаа. Тэгээд хуулийн төслийг дагаж боловсруулсан Цагдаагийн албаны тухай хууль, Дотоодын цэргийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль дээр ингэж тусгагдсан юм.

Тэгэхээр одоогийн энэ жагсаал, цуглааны энэ ихэнх эрх чөлөөний тухай хууль яг жагсаал, цуглааныг зохион байгуулаад тухайн цаг моментод тэр эсэргүүцлээ илэрхийлээд, эхнээсээ төгсгөл хүртлээ өрнөх энэ үйл явц. Энэ үйл явц өөрөө нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон, албадан тараах шаардлага үүссэн, бусдын амь нас, эд хөрөнгө, аюул учирсан энэ тохиолдолд өөр хуулиар зохицуулагдаад явдаг учиртай. Энэ тохиолдолд ямар хэлбэрээр албадан тараах юм, албадлага, хүч хэрэгслийг яаж хэрэглэх юм, жишээлбэл онц байдал зарлавал яах юм гэдэг тус тусынхаа хууль тогтоомжоор зохицуулаад байдаг онцлогтой.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Тэгэхлээр энэ хуулийн хэрэгжилт дээр бид нар энэ хууль бус гэдэг зүйл маань эргэж албадан тараах гэдэг зүйлтэй холбогдож, холбогдох энэ хэрвээ албадан тараах нөхцөл байдал үүсэхийн тулд холбогдож байгаа учраас холбогдох хууль тогтоомжид нь, бид нар дагаж орж байгаа хууль тогтоомжид нь өөрчлөлт оруулах зүйтэй гэж ингэж оруулсан юм. Миний тайлбар дээр манай ажлын хэсгийнхнээс нэмж хэлэх зүйл байна уу? Баасанжаргал гишүүний асуулт дээр. Ийм хариулттай. Дүгнэлтээ тэр хэд хариулах байх тээ?

Д.Цогтбаатар: Дэгийн тухай хуулиар яг энэ дүгнэлттэй холбогдуулж шууд асуулт асуух юу байхгүй байгаа. Гэхдээ энэ дээр яг агуулгатай нь би холбогдсон асуулт биш байна гэж үзэж байгаа. Тийм учраас Ариунхур дарга энэ дээр бас хариулах уу? 1 номерын микрофон.

Ч.Ариунхур: Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль ийн төсөл шинэчилсэн найруулгын хэлбэрээр өргөн баригдсан. Тэгэхээр чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 40.1 дүгээр зүйлд Байнгын хороо анхдагч болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэхдээ шинэ бүлэг, зүйл, хэсэг, заалт нэмэх, эсвэл өргөн мэдүүлсэн хуулийн төслөөс холбогдох бүлэг, заалт, хэсгийг хасах, бүтэц, найруулга, үг хэллэгийг өөрчлөх, засварлах тухай санал, дүгнэлт гаргана гэж заасан.

Өөрөөр хэлбэл, энд зарчмын зөрүүтэй саналын томьёоллын тоо юм уу, хуулийн төслийн тодорхой хувийг өөрчилж болно, болохгүй гэсэн хязгаарлалт байхгүй байгаа.

Түүнчлэн энэ шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал, дүгнэлт гаргахад энэ хуулийн 43-д заасан хүрээ хязгаар хамаарахгүй гэж заасан учраас хамт өргөн мэдүүлсэн нэмэлт, өөрчлөлтийн хуулийн төслүүдийн тухайд мөн яг энэ дээд талын 40.1-д заасны дагуу хэлэлцэх боломжтой.

Түүнчлэн хуулийн 40.4-д энэ хуулийн 40.1-д заасан Байнгын хорооноос.../минут дуусав./

Д.Цогтбаатар: 1 дүгээр микрофоныг гүйцээгээд өгье.

Ч.Ариунхур: 40.1-д заасан Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хууль санаачлагч эс зөвшөөрвөл хуулийн төслөө татан авч болно гэсэн зохицуулалт байгаа. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Өмнөх жагсаал цуглаанууд нь одоо хүчин төгөлдөр болж байгаа хуульд ингээд жагсаж цуглая гэхээр бүртгүүлэх гээд тэр хүсэлтээ өгдөг. Тэрийг нь бүртгэж авна, авахгүй асуудлууд гардаг. Тэгээд энэ ЧД, СБД-үүд дээр л гол жагсаал цуглаанууд болж байгаа шүү дээ. Ингээд тухайн дүүргүүдийн Засаг дарга нар бүртгэж авсан, зөвшөөрөл өгсөн өгөхгүй байна гээд л ингээд л бөөн асуудлууд болдог. Одоо бол энэ асуудал энэ хуулиар хязгаарлагдаж ер нь мэдэгдэл өгөөд ингээд жагсаал, цуглаан хийх эрхтэй болж байгаа юм байна гэж ойлголоо. Нээлттэй болж байгаа юм байна. Тэр мэдэгдэл өгч байгаа этгээдийг тухайн жагсаалыг зохион байгуулж байгаа этгээд гэж ойлгож

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

болох уу? Энэ хуулийн төсөлд юу гэж тусгасан бэ? Аливаа жагсаал, цуглаан хэн нэг этгээд хариуцах, зохион байгуулах, санаачлах заавал байж таараа. Тэгэхгүй бол энэ чинь ямар ч зохион байгуулалтгүй, нийгмийн эмх журам, дэг журам алдагдаад ингээд явах. Тийм учраас энэ мэдэгдэл өгөөд байгаа этгээдийг тухайн жагсаал, цуглааныг зохион байгуулж байгаа этгээд гэж ойлгож болох уу? Яагаад ингэж асууж байгаа гэхээр би дараа нь хариуцлагын асуудал яривал тухайн жагсаал, цуглаан эхлээд ямар асуудлаар жагсаж, цуглаж байгаад сүүлдээ бас ямар ч болохыг хэн ч үгүйсгэхгүй. Хил хязгаар хэтрэхийг үгүйсгэхгүй, сөрөг үр дагавар үүсэхийг үгүйсгэхгүй. Гэлээ гэхэд хариуцах субъект нь хэн бэ? Тэр мэдэгдэл өгсөн этгээд хариуцлагын асуудал хүлээх эрх бүхий этгээд мөн үү, үгүй юу гэдгийг? Энэ дээр хариулт өгөөч.

Сая Алтангэрэл сайд хоёрт тэр албадан тараах нөхцөл бий болсон нь тогтоогдсон гэж үзсэн тохиолдолд албадан тараана гэж байх шиг байна. Тэгвэл тэр шийдвэрийг тогтоогдсон гэж үзсэн энэ шийдвэрийг хэн гаргах юм? Тэр Тамгын дарга гаргах юм уу, цагдаагийн байгууллага тэгж тогтоох юм уу, аль эсвэл нам, улс төр гэдэг юм уу, дарга нар энэ тараа гэдэг энэ шийдвэрийг тогтоогдсон байна гэж үзсэн үндсэн дээр тухайн жагсаал, цуглааныг тараах гээд байна уу? Энэ дээр тодорхой хариулт өгөөч.

Аяндаа бий болсон жагсаал, цуглааныг, жагсаалыг мэдэгдэл хүргүүлсэн жагсаалын адил хүлээн зөвшөөрнө гэж байна. Аяндаа бий болсон жагсаал мэдэгдэл гэж, жагсаалыг юу гэж ойлгох вэ? Гуравт.

Дөрөвт, одоо чинь бид нар энэ сүүлдээ таавар таадаг болчихсон. Жагсаал, цуглаан болохоор энэ хэн зохион байгуулж байна, тэр зохион байгуулж байна, энэ зохион байгуулж байна, энэ улс төрийн нам, бараг сүүлдээ бараг эрх баригч намууд өөрсдийнхөө эсрэг жагсаал, цуглаан зохион байгуулж байна ч гэж хүртэл ярьдаг болчихсон. Тэгээд хэн, хаанаас ямар үндэслэл, зорилготойгоор зохион байгуулагдаж байгаа нь мэдэгдэхгүй ийм жагсаал цуглаанууд олон болчихсон байна.

Д.Цогтбаатар: Алтангэрэл сайдын микрофон өгье.

О.Алтангэрэл: Хуулийн төслийн 8 дугаар зүйлд бид нар энэ жагсаал, цуглааныг зохион байгуулах, мэдээлэх үйл ажиллагааны талаар зохицуулж өгсөн. Тэгэхээр 48 цагаас доошгүй хугацааны өмнө буюу 2 хоногоос доошгүй хугацааны өмнө мэдэгдэл өгье. Бид бол ийм бүрэлдэхүүнтэй ийм ийм жагсаал хийж байна, ийм зорилготой байна гээд мэдэгдэл өгнө. Тэгээд хариу өгсөн эсэхээс үл шалтгаалаад шууд жагсаал, цуглааныг хийх эрхтэй болж байгаа. Ингэхдээ жагсаал, цуглаан хийх мэдэгдэлдээ болохоор зорилго, эхлэх, дуусах хугацаа, оролцогчдын тоо, хэрэглэх эд зүйл, энэ байршил гэх мэтчилний зүйлүүдийг заавал тусгах зүйлүүдийг нь дурдаад өгчхөж байгаа юм.

Энийг яагаад хийв гэхлээр энэ зохион байгуулагчдын хүлээх, жагсаалд оролцогчдын хүлээх үүрэг нь бас хойно байгаа. Тэгэхээр энэ мэдэгдэл өгч байгаа этгээдийг зохион байгуулагч гэж үзэх үү гэдэг асуултад мэдэгдэл өгч байгаа этгээдийн энэ мэдэгдэх мэдэгдэлдээ өгсөн мэдээллийн хүрээнд жагсаал зохион байгуулагдаж байгаа учраас энэ хүрээнд оролцож байгаа оролцогчдын үүрэгжүүлчихсэн байгаа. Тэгээд бүгд энэ яриад байгаа үүргээ хүлээгээд ингээд явна гэсэн үг.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Тэр тараах шийдвэр дээр ер нь ингээд хамгийн их ярилцсан хэсэг байгаа юм ямар тохиолдолд гээд. Яг одоогийн байдлаар гэхэд л дөнгөж өнгөрсөн хоногуудын байдлаар л гэхэд л энэ жагсаал, цуглаасан этгээдүүдтэй хариуцсан нутаг дэвсгэрийн Засаг дарга нь энэ жагсаал, цуглааныг албадан тараах уу, үгүй юу гээд ингээд цагдаагийн байгууллагатай зөвшилцөөд тэгээд энэ дээр нь ингэж албадан тараах шаардлага байхгүй байна гэдэг байдлаар цагдаагийн байгууллага хэлээд явж байгаа.

Ер нь бас гишүүддээ мэдээлэл өгөхөд бид нар энэ хуулийн төслийг боловсруулахдаа энэ олон жил ярьсан жагсаал, цуглаан зохион байгуулахад учирч байгаа хүндрэл бэрхшээлийг арилгах, нөгөө талаар цагдаагийн албаны үйл ажиллагаанд тулгардаг энэ бэрхшээлүүдтэй холбоотой зүйлүүдийг бас давхар шийдвэрлэе гэсэн юм. Ерөөсөө хууль тогтоомжийн тодорхойгүй байдал эргээд цагдаагийн албан хаагчдыг шууд мухраар үүрэг өгчихдөг. Тэрийг биелүүлэх арга ажиллагаа, механизмыг зааж өгөөгүйгээс шалтгаалаад хүндрэл үүсээд байдаг. Тэгээд очоод энэ хууль бус жагсаал, цуглаан байна гэдэг угаасаа тэр нөгөө бүртгээгүй хууль бус юм чинь тэрийг албадан тараа гэдэг шийдвэр гардаг. Энэ бүх процесс нь нарийвчлан зохицуулагдаагүйн улмаас цагдаа болоод жагсагч иргэдийн хооронд маргаан үүсдэг тэгээд энэ үүссэн маргааны улмаас дараа дараагийн асуудлууд үүсээд явдаг энэ байдлыг л бид нар ер нь цэгцэлье гэж байгаа юм.

Тэгээд энэ жагсаал, цуглааны явцад анхны зорилго нь өөрчлөгдөөд тэгээд энэ хуулийн төслийн 10.4 буюу дайныг сурталчилсан бол, салан тусгаарлах, ялгаварлан гадуурхах энэ тэр гэсэн ийм агуулгатай болоод ингээд хувирчихсан бол жагсаал, цуглааныг албадан тараана гэж байгаа.

Албан тараахаар энэ цагдаагийн байгууллага албан тараах саналаа гаргая гэж байгаа юм. Энэ нутаг дэвсгэрийн аймаг, нийслэлийн ЗДТГ, сумын ЗДТГ-таа гаргана. Тэгээд 2 буюу түүнээс дээш сумын нутаг дэвсгэр дамжих юм бол аймгийн ЗДТГ-т хүргүүлээд Тамгын дарга шийдвэр гаргахаар ийм болоод байгаа юм.

Аяндаа бий болсон жагсаалыг бид нар оруулахаас арга байхгүй. Аяндаа бий болсон жагсаалыг маш товчхон тодорхойлох юм бол цаг үеийн нөхцөл байдлаас, өөрөөр хэлэх юм бол урьдчилж мэдэгдэл өгөх, нөхцөл байдал үүсэхгүйгээр гэнэтийн үүссэн нөхцөл байдал. Өнөөдөр ямарваа нэг хэлэлцэж байгаа шийдвэр, аливаа нэг газар болсон үйл явдал, цаг үеийн хэрэг учрал энэ юмтай тулгуурлан яг тухайн цаг мөчид бий болсон асуудал дээр, тухайн цаг үеийнхээ нөхцөл байдал дээр нэгдэж нийлж байгаа этгээдүүдээс та нар урьдчилж мэдэгдсэнгүй гэж ингэхгүй.

Харин ямарваа нэг байдлаар эсэргүүцэл олон хоногийн юм уу, олон хоногийн бэлтгэлтэйгээр аливаа юмны эсэргүүцэл, тэмцэл үзүүлж, байгаа үйл ажиллагааг.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Тийм бид нар Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль гэж байгаа. Тэгээд жагсаал, цуглаанд оролцож байгаа оролцогч эрүүл мэнд, амь насаараа хохирсон тохиолдолд яах вэ гэдэг харилцаа энэ хуульд байгаа юу?

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Нөгөө талаас жагсаал, цуглаан зохион байгуулж нийгмийн дэг журам, аюулгүй байдлыг сахиулж байгаа төрийн албан хаагч нар энэ цаг үед эрүүл мэнд, амь насанд нь эрсдэл учирсан тохиолдолд, хохирогч болсон тохиолдолд хэрхэн яах вэ, энэ хохирлыг оролцогчийн болоод албан үүргээ гүйцэтгэж байгаа төрийн албан хаагчдын хохирсон асуудлыг хэн хариуцах вэ гэдэг энэ асуудал энэ хуульд туссан уу үгүй юу? Хэрхэн, яаж зохицуулах вэ? Түрүүн та үгэндээ хэллээ маш харилцааг нь зохицуулаагүй асуудлуудаас болоод, чиг үүрэг нь тодорхойгүйгээсээ болоод, зохион байгуулж байгаа болоод төрийн албан хаагч нар буруутах асуудал үүсдэг гээд байгаа юм. Тэгээд энэ харилцаа энэ.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Ажлын хэсгээс хэн хариулах вэ? Алтангэрэл сайд. 5 дугаар микрофон.

Н.Мягмар: Сандаг-Очир гишүүний асуултад тодруулж хариулъя. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Мягмар. Энэ хууль маань бол Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль. Өөрөөр хэлэх юм бол үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хэрхэн зохицуулах вэ гэдэг энэ асуудлыг л олон улсын байгууллагуудын зөвлөмж, мөн Монгол Улсын Их Хуралд хүний эрх, эрх чөлөөний талаарх илтгэлүүдээр тавигдсан энэ үүрэг даалгаврын дагуу энэ хуулийн төслийг, мөн хэрэгжилтийн үр дагаварт бас үнэлгээний дагуу орж ирж байгаа хуулийн төсөл.

Яг энэ жагсаал цуглааны үеэр бусдын амь нас, эд хөрөнгө, эрүүл мэндэд хохирол учрах юм бол энэ хохиролтой холбоотой асуудал бол өөрөө Эрүүгийн хуулиараа жишээ нь амь нас, эрүүл мэнд хохирох юм бол, Зөрчлийн хуулиараа бол хохирол учраагүй боловч бусдын эрх чөлөөнд тодорхой хэмжээнд халдсан ийм үйлдлүүд нь бол Зөрчлийн хуулиараа ингээд явна.

Тэгэхлээр энэ Зөрчил шалган шийдвэрлэх болон Эрүүгийн.../минут дуусав./

Д.Цогтбаатар: 5 дугаар микрофон гүйцээж хариулах уу Мягмар дарга? 5 дугаар микрофон өгье.

Н.Мягмар: Тийм учраас энэ бусад хуулиараа бол энэ хохирол хариуцлагын асуудал бол гэм бурууг нь тогтоох асуудлаараа ингээд хууль хяналтын байгууллагын журмаараа явж энэ асуудал тогтоогдоно. Хэрвээ шүүхээс энэ нь гэм буруутай нь тогтоогоод бусдад эрүүл мэнд болон эд хөрөнгийн хохирол учруулсан бол тэр хохирлоо нөхөн төлүүлэх нь мөн бас шүүхийнх нь журмаар ингэж явж зохицуулагдана.

Тийм учраас яг энэ хуулийн зохицуулах харилцаанд бол яг тэр эд хөрөнгийг нь хэрхэн барагдуулах юм гэдэг энэ өөр бусад хуулиар зохицуулагдах харилцаа руу энэ хууль орж зохицуулагдаагүй.

Харин энэ хуулийг дагаад Зөрчил шалган, Зөрчлийн тухай хуульд бол зөрчлийг тодорхойлж оруулж ирж байгаа. Ийм дагасан хууль бол байгаа.

Нөгөө талаасаа бол энэ бусдын эрх, эрх чөлөөнд халдсан ийм үйлдэл үүсэх юм бол албадан тараах бас үндэслэл болно. Гэхдээ хүч хэрэглэсэн тэр үйлдэл болгоныг нь хууль бус гэж үзээд албадан тараалгах үндэслэл болохгүй гэдэг зохицуулалт бол бас хуулийн төслийн 13.6 дээр бол орсон байгаа.

Д.Цогтбаатар: Ажлын хэсгээс өөр нэмж хариулах уу? Номинчимэг гишүүний микрофоныг өгье. Алтанхуяг гишүүнийг юунаас түр хасаж байя жагсаалтаас.

О.Номинчимэг: Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн төсөл бас ингээд бидний нийгэмд тулгамдаж байсан олон зөвлөмж бас гарч байсан санал, зөвлөмжүүдийг бас тодорхой хэмжээнд тусгаад ингээд орж ирж байгаа учраас үзэл баримтлалын хүрээнд бас дэмжиж байна. Мэдээж Улсын Их Хурал энэ дээр ажлын хэсгээ гаргаад нарийвчилсан юмнуудыг нь нэлээн харна. Энэ хуулийг орж ирэхэд нийгмээс бас л ер нь бас асуултууд байдаг юм. Ялангуяа залуучуудын дунд.

Манай улс ингээд жагсаал, цуглаан зохион байгуулагдсан тоо баримтаас харахад 2023 онд 254 жагсаал, цуглаан, 2022 241 гээд ер нь ингээд өдөр болгон л бас ордны өмнө иргэд өөрсдийнхөө үзэл бодлыг илэрхийлж байна. Талбай дээр бас ингээд илэрхийлж байдаг. Ер нь бас энийг харьцангуй ингээд үзэл бодлоо илэрхийлэх боломжийг нээдэг улсын нэг. Гэхдээ энэ хуулийн төсөлд орж ирж байгаа гол нь яг энэ үзэл бодлоо илэрхийлэхээр орж ирсэн иргэдийнхээ үгийг яаж аюулгүй байдлыг нь хангах вэ, энийгээ бас яаж эрх баригчид нь энийгээ бодлогодоо тусгаж байх уу гэдэг асуудал их чухал байгаа.

Тэгээд энийг харахаар ийм юм нийгэмд бас ажиглагдаад байх шиг байна. Залуучуудын хувьд органик жагсаал гээд өөрсдийнхөө үнэхээр тулгамдаж байгаа асуудлыг, бухимдлаа илэрхийлээд жагсдаг. Ингээд жагсахаар дундаас нь жагсаалаа булаалгана гэдэг нэр томьёо гараад ирэх шиг байна тээ? Ингээд яг органикаараа хүсэл зоригоо илэрхийлээд жагсаж байтал үзэл бодлоо дундаас нь санаатай, санаагүй, төлбөртэй, төлбөргүй хүмүүс ороод жагсаалыг нь булааж аваад өөр тийшээ явуулчихдаг гээд. Ийм тохиолдлууд ер нь хэр их байсан юм бэ? Энийгээ энэ хуулиар ер нь зохицуулж байна уу? Бидний гол энэ эрх чөлөөг нь хангах гэж байгаа гол зорилтот бүлэг маань яг л энэ органик иргэд маань өөрсдийнхөө үзэл бодлыг илэрхийлэх эрх чөлөөг нь хангах, аюулгүй байдлыг нь хангах, стандарт орчныг нь бүрдүүлэх гэсэн асуудал дээр байгаа тээ. Түрүүн бас Сандаг-Очир гишүүн дурдаж байна. Ер нь ингээд манай жагсаалууд бүгдээрээ л янз бүрийн газраас санхүүжилт авчихсан төлбөртэй жагсаалууд болдог гээд. Энэ дээр ер нь Хууль зүйн яам энэ бусад байгууллага дээр үнэхээр нотлогдсон тоо баримтууд байна уу, судалгаа хийв үү?

Мөн Баасанжаргал гишүүнээс бас асууж байна. Энэ хуультай холбогдуулан өмнөх хууль дээрээ хийгдсэн хэрэгжилтийн тайлан гишүүдэд тараагдаагүй байна. Хэрэгжилтийн тайлан байвал гишүүдэд өгөөч. Байгаа юу?

Хоёрдугаарт энэ хуулийг олон нийтээр хэлэлцүүлсэнтэй холбоотой саналын ТОВЬЁГ-ийг бас гишүүдэд тарааж өгмөөр байна. Хуулийн бүрдүүлбэрт бас байх ёстой байх. Энэ одоогоор бас тараагдаж өгөөгүй учраас энийг бас энд гишүүд хүсэж байгааг хэлье. Асуултдаа хариулт авъя.

Д.Цогтбаатар: Алтангэрэл сайд хариулах уу?

О.Алтангэрэл: Хуучин хууль дээр нөгөө зэрэг зэрэг өөр жагсаал хийхийг хориглоод, тэгээд жагсаалын эсрэг жагсаал энэ тэр чинь бас хориотой байгаа шүү дээ. Тэгээд тэр төлбөр мөнгөөр татах нь хориотой гээд. Тэгэхээр энэ удаад

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ерөөсөө нэг дор ямар ч үзэл бодлоор хэдэн ч жагсаал хийхийг хязгаарлахгүй байдлаар ингэж оруулж байгаа юм.

Тэгэхээр тэр жагсаал булаалга нь гэдгийг харин ёстой юу гэж ойлгох юм байгаа юм. Нэг жагсаал дээр бусад этгээд ч гэсэн ямар өөр байдлаар үзэл бодлоо илэрхийлээд явах эрх чөлөөг нь энэ удаа дараагийн өгсөн зөвлөмжүүд энэ тэр дээр энийг нь та нар хаагаад байна, жагсаал гэдэг чинь ганцхан тэрийг эхэлсэн тэр зүйлээ биш өөр зүйлүүдийг бас ярьж болно. Тэр үеэр чинь хүмүүс яриад, тэр индрийг, тэр микрофоныг юм уу, тэр талбарыг ашиглаад өөр юм хэлж болно шүү дээ. Энийгээ та нар ер хязгаарлаад байгаа юм биш үү? Агуулга ярьдаг учраас энэ тохиолдолд тэгж оруулсан.

Жагсаалын тоо баримтууд байгаа. Ер нь хэдэн жагсаал болов гээд ер нь энэ бүртгэлтэй жагсаал, бүртгэлгүй жагсаалтыг үзэхээр бараг одоогийн байдлаар үзэхээр 87, 8 санаж байна. Манайх яг энэ үлдсэн асуултууд дээр тодорхой хариулчхаарай Номинчимэг гишүүний. Ер нь дийлэнх жагсаалт нь ерөөсөө энэ бүртгэлгүй л болдог юм байна лээ л дээ. Тэгээд дабл/double/ стандарт үйлчилдэг, заримдаа албадан тараана жагсаалыг. Бүртгэлгүй, та нар бүртгүүлээгүй зөвшөөрөл чинь хаана байна гэнэ, заримдаа өргөн бүрэлдэхүүнтэй бий болсон жагсаал юм уу, арай өөр зорилго нь өөр жагсаалууд дээр өөр өөрөөр харагдана. Тэгээд их энэ олон зөрчил нь даамжраад ирэхээрээ сүүлдээ яг л миний түрүүний дурддаг энэ жагсагчид болон цагдаагийн байгууллага өөрөөр хэлэх юм бол иргэн болон төрийн харилцаа болж харагддаг ийм л зовлонтой байдал үүсчхээд байдаг учраас энэ хуулиар бас зохицуулья гэж бодож байгаа юм. Тэр нь хэрэгжилтийн тайлантай холбоотой статистик тоо баримт, төлбөртэй, төлбөргүй гээд энэ Номинчимэг гишүүний асуусан асуултад манай ажлын хэсгийнхэн тодорхой хариулчихъя.

Д.Цогтбаатар: Аль микрофон хариулах вэ? 6 дугаар микрофон Лхагвасайхан дарга.

Н.Лхагвасайхан: Эрхэм Хууль зүйн байнгын хорооны дарга, гишүүдийн амрыг эрье. Хурандаа Лхагвасүрэн илтгэж байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд цагдаагийн байгууллагаас энэ жагсаал, цуглаан дээр дүн шинжилгээ хийж үзэхэд бол 1200 орчим жагсаал, цуглаан болсон байдаг. Эсэргүүцлийн арга хэмжээ. Энэ жагсаал, цуглаанд давхардсан тоогоор 16 мянга орчим иргэд оролцсон гэсэн тоо баримт гардаг. Энэ дээр цагдаагийн байгууллагаас тодорхой хүн хүч, техник хэрэгслээ ашиглаж аюулгүй байдлыг нь хангах чиглэлээр ажилласан.

Ер нь задлаад үзэх юм бол энэ Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль дээр энэ жагсаал гэж юу юм, цуглаан гэж юу юм гэдгийг тодорхой томъёолоод өгчихсөн байгаа. Ер нь нийтдээ жагсаал 188, цуглаан нь 1012 удаа зохион байгуулагдсан байна гэсэн ийм тоо байгаа. Ер нь.../минут дуусав./

Д.Цогтбаатар: 6 дугаар микрофоныг гүйцээгээд өгье.

Н.Лхагвасайхан: Дээрх жагсаал цуглааны арга хэмжээний 85.2 хувь нь нийслэлд болсон, 14.8 хувь нь орон нутагт зохион байгуулагдсан. Яг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжоороо энэ 89.6 хувь нь бүртгэлгүй, 10.4 хувь нь бүртгэлтэй явагдсан гэсэн ийм тоо баримт байдаг. Хариулт дууслаа.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Д.Цогтбаатар: Номинчимэг гишүүн тодруулъя. 4 номерын микрофон гүйцээж, бас нэмж хариулъя.

Н.Жамъянхүү: Номинчимэг гишүүний асуултад нэмж хариулъя. Хэрэгжилтийн үр дагаврын ер нь бол Хууль тогтоомжийн хуулийн дагуу болон Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн төсөл дээр бол энэ Хууль тогтоомжийн тухай хуульд заасан судалгаануудыг бол бүрэн хийсэн. Хэлэлцүүлэг, саналуудыг бол сүүлийн 2 жилийн хугацаанд бол нэлээн хэд хэдэн удаа хийж энэ санал зөвлөмжүүдийг бас л авсан байгаа. Тухайлбал, хэрэгжилтийн үр дагаврын судалгааг бол 2022 онд бол хийсэн. Мөн Улсын Их Хурлаас энэ гадаад орны харьцуулсан судалгаануудыг бол бас хийсэн байгаа.

Саад учруулах тал дээр бол мөн хуулийн төсөл дээр ялангуяа энэ 4.1.3 дээр тайван жагсаал, цуглаан гэдэг дээр бас мөн энэ саад учруулахтай холбоотой зохицуулалт, жагсаал, цуглаан хийх баталгаа дээр бас энэ холбогдох зохицуулалт буюу 15.4 дээр Зөрчлийн хууль дээр бас энэ саад учруулахтай холбоотой санкцыг, бас хариуцлагыг оруулж өгсөн байгаад байгаа юм.

Д.Цогтбаатар: Номинчимэг гишүүний микрофоныг өгье, тодруулъя.

О.Номинчимэг: Төлбөртэй жагсаалын тал дээр та хэд бас хэлж өгөөч. Энийг бас та бүгдээс судалгаа хийсэн олон улсын байгууллагын зөвлөмж авсны хувьд асууж байгаа юм. Яг ингээд нийгэмд явж байгаа хэлэлцүүлгийг харахаар аягүй их цаанаасаа санхүүжилттэй, мөнгөөр татаад энд тэнд явж байсан хүмүүс мөнгө тараагаад жагсаал, цуглаанд татан оруулдаг гэдэг юм байдаг тээ? Тэгээд бид нарын өнөөдөр хэлэлцэж байгаа хууль Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль. Тэгээд мөнгөөр татаад ингээд жагсаал, цуглаанд оролцож байгаа хүмүүсийн хувьд яг энэ үзэл бодлоо илэрхийлж байгаа жагсаал, цуглаан нь хийж байгаа хамгаалах ёстой эрх чөлөө гэж үзэх юм уу, яг яах юм? Олон улсын жишиг нь ямар байдаг юм? Энэ дээр та бүхэн ер нь яаж ажиллав? Энэ дээр бас нэмэлт хариулт өгчхөөч.

Хоёрдугаарт сая Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирж байгаа тэр хэрэгжилтийн тайлан болон саналын ТОВЬЁГ-ийг бас гишүүдэд өгөөч гээд хэлж байна. Дагалдаж орж ирээгүй байгаа учраас.

Д.Цогтбаатар: Алтангэрэл сайд.

О.Алтангэрэл: Энэ жагсаалын үеэр төлбөр өгсөн, мөнгө өгсөн, энэ хүмүүс мөнгө тараасан гэдэг асуудал байнга яригддаг. Тэгээд энэ Их Хурал дээр ажлын хэсэг маань Их Хурал дээр бас энэ жагсаал, цуглааныхаа хуультай холбоотой ажлын хэсэг гараад үүнийг Баярмаа гишүүн ахлаад явж байгаа юм байна лээ. Тэгээд гишүүд маань бас яг жишээлбэл энэ мөнгө төгрөгтэй холбоотой харилцааг нь судална, гаднын туршлага судална гээд бас нэлээн их судалгаа хийсэн байх. Тэгээд яг энэ хуулийн төсөл яригдаж байгаатай холбогдуулаад энэ асуудлаараа бид нар бас дэлгэрэнгүй мэдээлэл авъя. Дахиад хуулийн төсөл хэлэлцээд цаашаа явахад санал солилцъё гээд Баярмаа гишүүнтэй бас урьдчилан ярьсан зүйл байгаа.

Тэгэхээр яг энэ саяын тэр судалгаа, хэрэгжилтийн үнэлгээний тайлан зэрэг материалуудыг гишүүддээ бид нар бас тарааж өгье таны хэлснээр. Харин

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

манайханд яг төлбөртэй жагсаалт тэд болсон гэдэг статистик тоо баримт байвал Зөрчлийн хуулийн.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Лхагвасайхан хурандаа 6 дугаар микрофон.

Н.Лхагвасайхан: Яг ер нь жагсаал, цуглаан болж байгаа үед тэрний дараа энэ бие биеэ хардах юмнууд зөндөө гардаг. Ер нь төлбөртэй болчихлоо ингэлээ тэглээ гээд л. Яг цагдаагийн байгууллага өнөөдрийн байдлаар яг жагсаал, цуглаан төлбөртэй хийсэн гэдэг байдлаар шалгасан, хариуцлага тооцсон зүйл байхгүй.

Ер нь Зөрчлийн тухай хуулиар Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль зөрчсөн гэдэг үндэслэлээр бас сүүлийн 5 жилээр судалгаа гаргаж үзэхээр ер нь энэ 20 онд нийслэлд 20, орон нутагт 3, 21 онд нийслэлд 18, орон нутагт 2, 22 онд нийслэлд 19, орон нутагт 4, 23 онд нийслэлд 8, орон нутагт 1, 24 онд нийслэлд 9, орон нутагт арга хэмжээ авагдаагүй. Ер нь нийт 84 зөрчил бүртгэснээс 68 хүнд торгуулийн арга хэмжээ авч шийдвэрлэсэн ийм тоон мэдээ байгаа.

Д.Цогтбаатар: Номинчимэг гишүүн хариулт авч болов уу? Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийг хэлэлцэхийг дэмжиж байгаа. Энэ сая Алтангэрэл сайд хэлсэнчлэн 1994 онд жагсаал, цуглааны журмын тухай буюу тэр жагсаал, цуглааныг яаж журамлах вэ гэсэн үзэл баримтлалаар бичигдсэн хууль үндсэндээ 31 жилийн дараа хүний суурь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний нь нэг энэ жагсаал, цуглаан хийх эрх чөлөө юм. Өөрөөр хэлбэл энийг төрөөс зөвшөөрөл авдаг, журамладаг гэхээсээ илүүтэй хүний суурь, жам ёсны эрхийг эрх чөлөөг нь эдлүүлэх гэсэн энэ агуулгаар боловсруулж орж ирснийг талархан дэмжиж байна. Үнэхээр энэ дээр яах вэ 2 л асуудал үүсэх байх, гишүүд бас хөндөж байна. Энэ эрх чөлөө, манайх бол ардчилсан улс жагсаал, цуглааныг хүч хэрэглэн ингэж тараахаасаа илүү ойлголцож, тэр эрхийг нь эдлүүлэх талд хамгийн тэргүүн фронтод яг цагдаагийн байгууллага, албан хаагчийг бас нүүр тулдаг. Тэр маань хүн байдаг.

Тийм учраас энэ чинь ялангуяа олон нийтийг хамарсан ийм үед эмх замбараагүй байдал, бусдын амь нас, эд хөрөнгө сүйтгэхээс урьдчилан сэргийлэх чиглэлд ихээхэн тийм ур чадвар, ухаан шаардсан ийм ажиллагаанууд болдог.

Сүүлийн үеийн энэ жагсаалуудыг харахад энэ Номинчимэг гишүүн хэлээд байгаа юм төлбөртэй жагсаал гэж яриад байгаа юм. Энэ ерөнхийдөө ийм жагсагч гэдэг тийм мэргэжил эзэмшсэн хүмүүс бүүр гараад ирчихсэн юм шиг байгаа юм. Ер нь ард түмэн ч мэддэг болчихож дээ. Өнөөх чинь гэдэг, бараг зарим нь ханштай ч юм шиг ингээд юм болгон жагсаж байдаг ч юм шиг ийм хүмүүс гарсан. Анх Баасан эгчээс л эхэлсэн юм шиг байгаа юм. Одоо бол Баасан эгч маань төлөвшөөд сайн хуульч, өмгөөлөгч болон ажиллаж байна.

Тэгээд энэ Солонгос их сонин зүйл би анзаарсан нь Солонгосын жагсаал зохион байгуулдаг ийм компаниуд байх шиг байгаа юм. Өөрөөр хэлбэл, энэ нөгөө төлбөртэй жагсаал гэдгийг бүүр хуульчлаад, зөвшөөрөл олгоод, тэр нь яагаад байна вэ гэхээр гол нь нөгөө жагсагчдын зохион байгуулалтад оруулж, тэр эмх замбараагүй байдал алдагдахаас сэргийлэх, тэр хариуцлагыг үүрэх этгээд байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр мөнгөө төлөөд жагсаал зохион байгуулаад

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

байдаг юм байна лээ шүү дээ энэ Солонгос чинь. Тэгээд энийг бас судалж үзмээр ч юм шиг санагдаад.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Энхбаяр гишүүний микрофоныг гүйцээгээд өгье.

Б.Энхбаяр: Энэ хаашдаа манайхан чинь нөгөө иргэн О, иргэн Т эд нар гээд мэддэг болчихсон шүү дээ төлбөртэй жагсагчид гээд. Тэгээд эд нараас татвар авъя ер нь. Хуучин төрөөс төрчихсөн тэрбумтан энэ тэр гээд ярьдаг байсан. Одоо жагсаалаас тэрбумтнууд төрдөг болчихсон байна шүү дээ. Тийм жагсаалаас. Тэрийгээ ил тод хэлдэг, хүмүүс мэддэг эд нар болчихсон сүүлд бүр Хууль зүйн яаман дээр оччихсон жагсчихсан явж байсан уу яасан. Тэр нөхдөөс ер нь татвар авъя, тэгээд тэр ХОМ-ыг нь бөглүүлэе. Мануус болохоор ХОМ бөглөөд л л их яваад байдаг, нөхөр болохоор ард түмний нэр бариад л тэрбумтан болчихсон суугаад байдаг эд нар. Одоо татварыг нь авъя. Тэгэхээр энэ дээр сайд маань бас ямар санал, бодолтой байдаг юм доо?

Д.Цогтбаатар: Алтангэрэл сайд их болгоомжтой яг хуулийн хүрээнд хариулахгүй энэ ноцтой юм асууж байна шүү.

О.Алтангэрэл: Ер нь сая манай цагдаагийн байгууллагаас өгч байгаа тайлбар дээр гарч байгаа юм. Жагсаал, цуглааны журмын тухай хууль зөрчсөн гэдэг үндэслэлээр Зөрчлийн хууль дээр тэгэхээр жагсаал, цуглаан чинь одоо байгаагаараа үнэ, мөнгөөр татаж болохгүй энэ тэр гэж байгаа шүү дээ. Тийм болохоор нэг талаараа бас хүний эрхийг хязгаарлах үндэслэл болчихоод байгаа юм.

Ер нь ингээд энэ Алтангэрэлд мөнгө өгсөн үү, чамд Алтангэрэл мөнгө амласан уу гээд л ингээд л асуугаад л, байцаагаад ирэхээрээ л тэр шинж рүүгээ орчихоод байгаа юм л даа. Тэгэхээр бид энэнээс нь ер нь гаргаад тэр шинжийг нь хуулиас хасчихсан юм. Ямар ч байсан 1 алхам, хуучин бол мөнгө төгрөгөөр болохгүй, энэ Жагсаал, цуглааны хууль зөрчсөн болно гэдэг байсан бол ямар ч байсан энийг хасчихсан 1 алхам.

Би түрүүн хэлээд байдаг манай Их Хурлын ажлын хэсгийн Баярмаа гишүүн тэргүүтэй гишүүд маань БНСУ руу явсан. Тэр бүрэлдэхүүн бас яг бүрэлдэхүүнийг нь харахад жагсаал, цуглааныг нэлээн ойлгохоор, мэдэхээр тийм бүрэлдэхүүн байсан. Тэгээд яг энэ таны саяын хэлж байгаа энэ санаа, энэ зүйлүүдийг бас хэлж байна лээ. Бүр ийм зарчмын шинжтэй өөрчлөлтүүдийг бид нар бас энэ хуулийн төсөл дээр, явц дээр нь оруулмаар байна гэдэг санааг хэлж байна лээ. Тэгэхээр хэлэлцэгдээд ирэхээр таны санааг тусгаад ингээд бас улсын төсөвт тэр төвлөрүүлэх тэр асуудлыг бас судлаад ярилцаж болох байх.

Д.Цогтбаатар: Эрдэнэболд гишүүнд микрофон өгье.

С.Эрдэнэболд: 2024 онд манайх энэ хүний эрхийн индексээрээ 10-аас 4.4 оноо авч байгаа юм. Тэгэхээр яг би тодорхой асуулт асууя. Юу гэхлээр түрүүн энэ хуулийн хэрэгжилтийн үр дагавар гэж яриад байгаа шүү дээ. Нөгөө талдаа ингээд симуляц бид нар энэ дээр хийх шаардлагатай юм шиг байгаа юм. Жишээлбэл, энэ хүний эрхийн индекс унаж байгаатай холбогдуулаад улс төрийн эрхээ эдлэх буюу үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, жагсаал, цуглаан хийх эрх чөлөө хумигдмал байдал нь өөрөө энэ индексийг унахад хэчнээн коэффициент

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хамаараад байгаа юм бэ гэж. Тэгэхээр энэ хууль хэрэгжээд тодорхой нийгэмд хэм хэмжээний үйлчлэл үзүүлсэн тохиолдолд энэ хүний эрхийн индекс ямар төлөвөөр сайжрах юм бэ гэсэн ийм симуляц маягийн зүйлийг хийсэн үү, эс үгүй хийгээгүй байгаа юу? Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаарт нь гэх юм бол 24 оны 4 сарын 22 буюу яг 1 жил буюу 365 хоногийн өмнө энэ хуулийн төсөл Хууль зүйн яамнаас веб сайтад нийтлэгдээд 11 сарын 22-ны өдөр нь болохлоор 60 орчим хүнтэй хэлэлцүүлэг хийсэн гэсэн энэ тайлбар дээр гарч ирж байна л даа. Тэгэхлээр энэ бол тийм хангалттай бас сонсогдохгүй л байгаад байгаа юм. Жишээлбэл, цахимаар тавьсан зүйл дээр хэчнээн хүмүүс санал бодлоо илэрхийлсэн юм, тэдний хэд нь жишээлбэл энэ төсөлд орсон юм, тэр 11 сарын 22-ны өдрийн хэлэлцүүлгээс гол гол ямар санаанууд гарсан юм эд нар гэдгийг нь эндээ бас тусгаад тэр нь иргэдийн үзэл бодол яаж туссан юм, иргэний нийгмийн байгууллагуудын үзэл санаануудыг, коментуудыг, сэтгэгдлүүдийг хангалттай энд оруулсан юм уу, үгүй юү гэдэг мэдээлэл баймаар байгаа юм.

Дараагийн зүйл нь болохлоор энэ тоо баримтыг харж байхад 14 онд 115, 15 онд 140 гэж явсаар байгаад 22 онд 241, 23 онд 254, 24 оны 8 сарын байдлаар 155 буюу одоо ингээд 200 орчим. Тэр жилд Монгол Улсад 200 орчим, 200 гаран жагсаал, цуглаан болж байгаа юм байна. Тэдгээрийн хэчнээн нь жишээлбэл яг энэ улс төртэй холбоотой засаг төрийг шүүмжилсэн юм бэ? Энэ дээр бас тоо статистик байна уу, үгүй юү гэж асуумаар байгаад байгаа юм.

Хуулийн үзэл санааг дэмжиж байгаа шалтгаан нь бол энэ бүртгүүлэх нэртэй боловч зөвшөөрөл авдаг тогтолцоог халах гэдэг бол энэ хүний эрхэд маш том боломж авчрах болов уу.

Хоёрдугаарт нь энэ ямар нэгэн байдлаар энэ жагсаал, цуглаан санаачлан зохион байгуулах этгээдийн хүрээг өргөжүүлж байгаа гэдэг нь бол бас их давуу тал үүсгэж байгаа юм болов уу гэж харж байгаа юм.

Ер нь бол ордноос удирдлагатай жагсаал бол их хангалуун болдог. Гэр бараа талбай дээр бариулдаг, их дипюзер, хөгжим сайтай болдог шүү дээ. Яг органикаараа боссон жагсаал сүүлийн жилүүдэд тэр болгон үр дүнд хүрэх, одоо энэ засаг төрийн бодлого буруу байгаа дээр яг байндаа тусдаг юм их хазаарлагдсан, хязгаарлагдсан, гуйвдаг болсон. Энэ дээр бол сая гишүүд ч гэсэн хэлээд байгаа энэ төлбөртэй жагсаал гэж хэлээд байгаа. Тэгэхээр энэ.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Эрдэнэболд гишүүний микрофоныг гүйцээгээд өгье.

С.Эрдэнэболд: Энэ дээр болохлоор ийм давхар стандарт үйлчлээд байгаа юм. Жишээлбэл, манай улсын хамгийн том албан тушаалыг хашиж байгаа хүмүүс шууд хэвлэл мэдээллээр энэ жагсаал төлбөртэй жагсаал, тэр тэр нар төлбөрийг нь төлж байна, сая он давхцах мөчид гарсан шүү дээ хувийн компани энийг санхүүжүүлж байна, дотоодын цэргийн генерал энийг санхүүжүүлж байна ч гэдэг ч юм уу. Ер нь ингэх чинь зөв юм уу? Улс төрчид өөрсдөд нь таалагдсан хийгээд, таалагдаагүй жагсаалыг шууд нэр заагаад, тэгээд хүмүүсийг шууд айх сэтгэл зүйг нь накаунт оруулах хэмжээнд оруулаад тухайн жагсаалын магадгүй ач холбогдол ч гэдэг юм уу, магадгүй энэ нийгмийн критикал майндейд/critical minded/ гэж хэлдэг

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

тэр шүүмжийн сэтгэлгээг хязгаарлах нөхцөл байдал үүсчих юм биш үү? Энэ зүгээр 1 хүний асуудал биш л дээ. Цаашдаа бол төрийг удирдаж байгаа хүмүүс нь гарч ирээд л өөрт таалагдахгүй байгаа жагсаалуудаа шууд энэ ийм байна, тийм байна гээд л хүмүүсийг айлгаад явчихдаг чинь зөв юм уу, үгүй юү тээ? Энэ дээр жишээлбэл энэ хуулийн зохицуулалт байх юм уу? Тэгээд энэ чинь хэн нэгэн.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Алтангэрэл сайд.

О.Алтангэрэл: Энэ хүний эрхийн индексийн асуудал чухал асуудал. Бид энэ дээр яг симуляц хийсэн гэхээсээ илүүтэйгээр энэ Хүний эрхийн Үндэсний комиссоос гаргадаг жил болгоны Хүний эрхийн төлөв байдлын илтгэл дээр тавьсан шаардлагууд дээр бид нар үндэслэж яримаар байгаа юм.

Тэгэхээр 2002 оны энэ чинь анхны илтгэл байсан байх 2004 оны 3 дахь илтгэл, 2010 оны 8, 2020 оны 18 дугаар илтгэл гээд энэ онуудад гарсан Хүний эрхийн Үндэсний комиссоос гарсан хүний эрхийн чиглэлээр гарсан илтгэлүүдэд дурдагдсан асуудлуудаас бид нар яг тооцоолоод үзэхэд 70 хувийг нь энэ хуулийнхаа төсөлд тусгачхаад байгаа юм. 70 хувь нь эндээс өгсөн зөвлөмжүүдээс яг өнөөгийн энэ хуулийн төсөл дээр. Тэгэхээр энэ чинээгээрээ Хүний эрхийн Үндэсний комиссоос гарч байгаа энэ илтгэл маань өөрөө олон улсын хүний эрхийн стандарт, Монгол Улсын хууль тогтоомж, хэм хэмжээтэй холбоотой гардаг учраас бид нар энэ Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлийг шийдвэрлэсэн хувиараа бид нар яг энэ төсөлд орчихсоныгоо 70 хувь гэж хэлнэ.

Тэгээд энэ чинээгээр харин нийт хүний эрхийн индекс дотор энэ үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө, тэр дундаас энэ жагсаал цуглааны эрх, эрх чөлөө ямар үнэлгээ аваа аваад яаж гарч байгаатай холбогдуулж нарийн бас хэлж чадахгүй байна. Ер нь энэ хүний эрхийн индекс их олон төрөл, зүйлээс шалтгаалж гарч байгаа байх. Ямартай ч зохицуулах гэж байгаа харилцаа буюу энэ тайван жагсаал, цуглаан гэж энэ асуудал дээр бид нар яг одоогийн байдлаар олон улсын байгууллагууд, Хүний эрхийн Үндэсний комиссоос тавьсан энэ илтгэлүүдийн хүрээнд өгсөн зөвлөмжийг бид нар 70 хувийг нь тусгачихсан гэдэг өөрсдийн хийсэн бид нар ийм судалгаа байна.

Ингээд жилд болж байгаа жагсаалуудаас ингээд сэдвүүд, сэдвүүдээс ингээд яг ангилаад үзэхээр өөрт тулгамдсан асуудлаа шийдвэрлүүлэх гэдэг энэ жагсаалын тоо хэмжээ нийт өнгөрсөн 5 жил болсон жагсаал, цуглаануудаас хамгийн өндөр нь байна. Цаг үеийн шинжтэй үйл явдлууд гэсэн үг. Улсын Их Хурал болон аймаг, нийслэл, сум, дүүргийн энэ сонгуультай холбоотойгоор өндөр хувийг эзэлж байна. Энэ жагсагчид тэмцэгчдийн энэ байгалийн баялагтай олборлолттой холбоотой нөхцөлд дараа нь орж байна. Улсын Их Хурлын ээлжит чуулганы нээлт, хаалтын үеэр нэлээд олон идэвхжил ажиглагдаж байна. Төрийн байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийн талаар Засгийн газрын гэнэтийн шийдвэр, тогтоолын талаар гэсэн ийм агуулгуудаар ийм хийчихсэн судалгаа байна. Танд бас өгье.

Энэ жагсаал, цуглааны талаарх яг мэдээллийг яах вэ гэдэг харилцааг энэ хууль дээр ерөөсөө зохицуулаагүй. Тэгэхдээ бид юу гэж үзэж байгаа вэ гэхлээр жагсаал, цуглаан хийх эрхийнхээ асуудлыг баталгаажуулаад өгчихвөл, энэ эрхээ баталгаажуулаад авчихвал энэ үйл явдалтай холбоотойгоор оролцож байгаа энэ

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

албадан тараахтай холбоотой юм уу, эсвэл хуучин хуульд байсан олон хязгаарлалтууд нь байхгүй болоод ирвэл илүү чөлөөтэй үзэл бодлоо илэрхийлээд явах байх. Тэр тухайн жагсаал, цуглааныг шударга байна уу, шударга бус байна уу, эсвэл зөв үү, буруу юу гэдгийг илэрхийлэх дээр хувь хүний хувьд эрх эрх чөлөө харагдах байх.

Харин таны хэлж байгаа агуулгаар төрийн байгууллага, албан тушаалтан тэр дундаа төрийн эрх мэдэл бүхий этгээдүүд жагсаал, цуглааны талаар албан ёсны гэдэг юм уу энэ байр суурийг яаж илэрхийлэх ёстой юм. Ер нь жагсаал, цуглааны талаарх оролцогчдын тоо юм уу, үүсэж байгаа нөхцөл байдлын талаар мэдээллийг олон нийт яаж хүргэх юм бэ гэдгийг бас нэмж хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад нэмж тусгаж бас тусгах нь бас зүйтэй юм байна гэж ингэж бодож байна.

Д.Цогтбаатар: Би ганц, хоёр асуулт асууна. Гишүүд асуултаа асууж дууслаа.

Тэгэхлээр энэ Дэгийн тухай хуулиараа дүгнэлт гаргасан нэгжээс асуулт шууд асуух дэг байхгүй байгаа. Би түрүүн хэлсэн. Гэхдээ 34.4 дээр Дэгийн тухай хуульд энэ хуулийн асуудал хариуцсан нэгжээс танилцуулж, тайлбар хийнэ гэж байгаа юм. Тэгэхлээр би тайлбар авах асуудал гарч ирнэ. Тэр юутай холбогдсон гэхлээр энэ яг ийм байгаа юм Алтангэрэл сайдаа энэ гоё томъёологдоод орж ирж байгаа юм. Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль гээд гоё сонсогдож байгаа биз? Би ийм гоё юм төр томъёолоод ороод ирэхлээр л өөрийн эрхгүй хардах сэтгэл төрөөд явчихдаг юм.

Яагаад гэвэл яг гоё юмны ард муухай юм нуугдаж байдаг. Тэгэхлээр та нар маань зөв юм сэдээд би энэ хуулийг анхнаас оруулж ирэхэд нь Алтангэрэл сайдыг дэмжиж байсан энийг оруулж ир гээд. Тэгэхдээ Ардчилсан Конго улс, Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улс ерөөсөө ардчилсан байгаагүй. Нэр нь тийм байсан байхгүй юу.

Тэгэхлээр энэ дээр сайжруулах гээд би саяын танилцуулга эд нараас харж байхад хориглосон зүйл, заалт урьд хуульд байгаагүй юман дээр их тодотгоод юм хориглоод оруулаад ирэхлээр урьд хуульд байгаагүй хоригууд нэмэгдээд ороод ирж байгаа юм биш биз дээ? Энэ чинь тэгвэл юмыг сайжруулах гээд муужруулчихсан юм болж хувирна шүү. Энэ яг хууль зүйн, манай Тамгын газраас гаргасан дүгнэлт дээр 1 дүгээр хэсэг дээр нь яг төгсгөлд нь ингэж бичсэн байгаа юм л даа. Уг эрх чөлөөг хязгаарласан зохицуулалт цөөнгүй байгааг анхаарахыг зөвлөж байна гээд. Одоо энд Хүний эрхийн комиссынхон байхгүй байна. Ийм хууль орж ирж байхад Хүний эрхийн комиссынхон ирээд суудаг байх ёстой шүү. Энийг бас сануулаад хэлчихмээр байна. Уг нь асуувал Хүний эрхийн комиссоос асуух гээд байхгүй юу. Тэгээд нөгөөдөх нь байхгүй байгаа учраас тайлбар маягаар би Тамгын газраас л асуух гээд байна л даа. Тайлбар байхгүй юу. Энэ ингээд хязгаарласан зохицуулалтууд орж ирж байна гэдэг чинь энэ сайхан үгэндээ таарсан Эрх чөлөөний тухай хууль болчхов уу, энийг хязгаарлах нөхцөлийг муутгасан хууль болчхов уу? Энэ дээр тайлбар өгөөч.

2 номер.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Г.Агар-Эрдэнэ: Гишүүний асуултад хариулъя. Тамгын газрын гаргасан хууль зүйн дүгнэлтэд бас дурдсан хүрээнд хариулъя. Тухайлбал, одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд жагсаал, цуглаан хийхийг хориглох газрыг бол тодорхойлсон байгаа. Энд тодорхой нэр төрлийн газруудыг дурдсан. Харин шинэ төсөл дээр бас хориглох газруудыг бас жагсаасан байгаа. Энэ дээрээ одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиас зарим хориглосон байршлыг өргөжүүлсэн шинжтэй байна гэдэг дүгнэлтэд дурдсан. Венецийн комиссын эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний талаарх байр суурийн эмхэтгэлд болон НҮБ-ын Хүний эрхийн хорооноос өгсөн зөвлөмжүүдэд дурдсанаар бол энэ жагсаал, цуглаан хийх байршлын асуудал дээр бол аль болох чөлөөтэй, тайван цуглааныг зарчмын хувьд нийтийн гудамж, талбай гэх мэт олон нийт чөлөөтэй нэвтрэх боломжтой бүх газар хийхээр зохицуулах нь зүйтэй гэсэн байгаа.

Тэгэхлээр одоогийн төсөл дээр бол өмнөх буюу одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиас ялгаатай нь гэвэл тодорхой жишээ дурдахад Төрийн тусгай хамгаалалттай бүс дээр бол жагсаал, цуглаан хийхийг хориглосон байгаа. Энд бол Төрийн тусгай хамгаалалтын байнгын болон түр бүсийг оруулж өгсөн. Энэ нь бол одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиас бас түр бүсийг нэмж оруулснаараа ялгаатай байгаа.

Мөн Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор бас энэ тусгай хамгаалалттай, төрийн тусгай хамгаалалтад байх зүйлсийн жагсаалтыг баталж байгаа. Мөн улсын онц чухал объектын жагсаалтыг баталж байгаа. Төсөлд бол онц чухал объектуудад бас жагсаал, цуглаан хийхийг хориглосноороо Засгийн газар бас өөрөө энэ тогтоолоороо тухайн хориглосон газруудын байршлыг өргөжүүлэх ийм эрсдэл байна гэж дүгнэлтэд дурдсан байгаа.

Д.Цогтбаатар: Алтангэрэл сайдын микрофоныг өгье.

О.Алтангэрэл: Тийм, тэгээд энэ дэгийн тухай хуулийн заалттай холбогдуулаад энэ дүгнэлт гаргаад энэ дээр бид өөрсдөө дүгнэлтийн асуудлыг бас энэ зарим нь яагаад нийцэхгүй байна, зарим нь яагаад энэнтэй нь бид нар үзэл бодол болоод яг үнэхээр бодит сонин судалсан юм нийцэхгүй байна гэдэг талаар бид нар бас ингээд дүгнэлттэй холбогдуулаад гаргасан.

Бид ер нь цаашдаа бодууштай юм байна лээ. Энэ хуулийн төслийг маш удаан хугацаанд манай Энхбаяр сайдыг сайд байхад манай залуучууд хийж л байсан, намайг байхад хийж л байна. Ингээд олон удаагийн хэлэлцүүлэг хийгээд, зөвлөмжүүд хийгээд, урт удаан судалгаа хийгээд гаргаад ирдэг. Тэгэнгүүт бас тодорхой хугацаа өгөөд энэ хэлэлцүүлэгт ерөөсөө оролцоогүй, энэ хэлэлцүүлэгт ямар байдлаар зарим зүйл, материалыг нь үзээгүй ийм хүмүүсээр дүгнэлт гаргуулчихдаг. Энэнээс нь шалтгаалаад тэр дүгнэлтийг нь бид нар хэрвээ талууд нь байх юм энэ дүгнэлтийнх нь талаар мэтгэлцэж болох юм уу, ярьж болох юм уу, тайлбарлаж болох юм уу гэдэг байх. Саяын асуудал дээр гэхэд л бид нарт аягүй тийм шалтгаан бүхий тайлбар байгаа. Дарга 4 номер манай Жамъянхүү.

Д.Цогтбаатар: 4 номерын микрофоныг өгье.

Н.Жамъянхүү: Асуултад нэмж хариулъя. Бид нар хамгийн гол нь цаад энэ жагсаал, цуглаан, үзэл бодлоо илэрхийлэхийн гол цаад үндэс суурь нь бол энэ

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын факт байгаа. Тэгэхээр энэ фактын 21 дээр бол тодорхой зорилгуудын хүрээнд бол тодорхой заалтуудыг хийж болно гэгдсэн. Ялангуяа үндэсний аюулгүй байдал, нийгмийн аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, ёс суртахууныг хамгаалах, бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах гээд ийм хүрээ хязгааруудыг бол хүрээнд бол хязгаарлалт хийж болно гээд байгаа юм.

Бид нарын судалгааны хүрээнд бол дандаа энэ Герман, Солонгос, Швед гээд улсууд бол яг энэ хязгаарлалтуудын хүрээнд тодорхой хязгаарлалт ялангуяа нийгмийн аюулгүй байдал, үндэсний аюулгүй байдалтай холбоотойгоор зарим объектуудад бол юу хийж болохгүйгээр хязгаарласан байгаа.

Тусгай, түр хамгаалалттай газар гэдэг бол ялангуяа.../минут дуусав./

Д.Цогтбаатар: 4 дүгээр микрофон гүйцээгээд хариулъя.

Н.Жамъянхүү: Одоогийн хууль дээр бол бас байгаа нөгөө тусгай хамгаалалттай газар гэдэг байгаа. Тэгэхээр энэ Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль дээр бол байнгын болон түр гэсэн ийм хамгаалалт байгаа. Тэгэхээр энийг бол энэ төр Төрийн тусгай хамгаалалтын тухай хуультай нийцүүлээд бол түр хамгаалалт буюу зарим тохиолдолд өндөр дээд хэмжээний айлчлал болон өндөр дээд хэмжээний жишээ тухайлбал Орос Холбооны Улсын Ерөнхийлөгч Путин ирж байхад энэ дээр түр хамгаалалт авч байсан. Энэ дээр бол ялангуяа тэр жагсаал, цуглаан хийхтэй холбоотой зохицуулалт байхгүй учраас ялангуяа энэ практик, дээр нь хуульд нийцүүлэх байдлаар энэ түр гэдгийг бол оруулж өгч.

Дээр нь бол онц чухал объектыг жагсаалтыг бол Засгийн газрын тогтоолоор баталж байгаа. Энэ бол ялангуяа цэвэр усны болон энэ эрчим хүчний гээд Монгол Улсын онц чухал объектуудыг бол хамгаалах энэ объектууд дээр бол жагсаал, цуглаан хийхгүй байх ийм хязгаарлалт орчихсон байгаа юм.

Д.Цогтбаатар: Хоёр дахь би асуулт асуугаадахъя. Би яагаад энийг асууж байгаа гэхлээр Алтангэрэл сайд би бодоогүй асууж байгаа юм биш. Энэ чинь ийм байхгүй юу. Энэ хуулиар Монгол Улсад жагсаал, цуглаан зохион байгуулах эрх чөлөөг тодотгох шаардлагагүй юм. Энэ чинь өөрөө Үндсэн хуульд заагдчихсан халдашгүй эрх чөлөө байхгүй юу. Тэгсэн та нар энэ хууль чинь тэрийг харин хязгаарлах яг Ай Си Пи Ар-ын 21 дүгээр зүйлийг ярьж байна шүү дээ. 21 дүгээр зүйлийн 2 дахь өгүүлбэрээс эхлээд тэр хязгаарлах хэм хэмжээнүүд орж ирж байгаа юм. Тэр нь тэр хязгаарлалтууд эрх чөлөөг хязгаарлаж байгаа гэсэн үг биш гэж олон улсын хуульд өөрөө зааж өгч байгаа байхгүй юу. Тэгээд тэрийг тодотгож оруулж ирж байгаа хууль байхгүй юу энэ. Өөрөөр хэлбэл, тэгтэл та нар энд хар нэр томъёо дээр чинь Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай гэж байгаа биз. Тэгсэн мөртөө зорилт хэсэг дээрээ 1.1 дээрээ болохлоор хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулах буюу тэр эрхийг ямар хэмжээнд хязгаарлаж өгөх вэ гэдгээ тэр эрх чөлөөгөө эдэлж байхад нь ямар хэмжээнд хязгаарлалтууд хийх вэ гэдгийг зохицуулж байгаа хууль байхгүй юу энэ чинь.

Түүнээс тэр эрх чөлөө аль хэдийн тунхаглагдсан ийм органик хуулиар эрх чөлөөг өгнө гэж байхгүй. Хэн ч угаасаа авч чадахгүй юм байхгүй юу. Энийг кристаллизац хийж тодотгох уг нь шаардлага байхгүй юу. Тийм учраас би энэ юуг

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

асуусан байхгүй юу. Тэгээд энэ дээр 4.1.2 дээр юу байна л даа заалт. Энэ жагсаал гэдэг үгийг тодорхойлчихсон байгаа юм. Тэгээд 4.1.3 дээрээ тайван жагсаал, цуглаан гээд ингэхлээр хоёулаа аль алинд нь жагсаал гэдэг үг орчихсон. Тэгэнгүүтээ тайван гэдэг тодотгол болохлоор тэр нь арай өөр жагсаал болчих гээд байгаа юм шиг. Тэгэхлээр нөгөө тайван бус жагсаалыг тодорхойлоод та нар жагсаал гээд хийгээд өгчихсөн байна л даа.

Тэгвэл Монгол Улсын Үндсэн хуулийн 16.6 болон айн? Тийм 16.16 сорри/sorry/. Үндсэн Хуулийн 16.16 болон энэ Ай Си Си Пи Ар энэ олон улсын Иргэний болон улс төрийн болон нийгмийн эрх, иргэний эрх чөлөөний тухай конвенцын 21-д чинь зааснаар зөвхөн пийсфул эссембли/peaceful assembly/ гэж байгаа байхгүй юу. Үндсэн хуульд тайван жагсаал, цуглаан ярьж байгаа байхгүй юу. Тэрнээс өөр жагсаал, цуглаан энэ улсад харин Үндсэн хуулиараа ч зөвшөөрөгдөөгүй. Та нар энд тодорхойлоод оруулаад ирэхлээр энэ эрхийг өгөөд байгаа юм биш биз дээ? Үндсэн хуульд олгогдчихсон эрхээс давсан эрх ойлголтыг бий болгох гээд байгаа юм биш биз дээ гэдэг ийм асуулт гарч ирж байна.

Алтангэрэл сайд хариулах уу?

О.Алтангэрэл: Таны агуулгаар, ер нь таны саяын хэлж байгаа энэ агуулгаар л ер нь хуулийн төслийн үзэл санаа бид нар ингэж хандаж явж байгаа. Тэгээд ерөөсөө одоо энэ дайныг сурталчилсан, салан тусгаарлах үзлийг сурталчилсан гэдэг ч юм уу ингээд энэ хуулиар үргэлжилснийг бид нар хууль бус жагсаал, цуглаан гэж нэр томъёоны хувьд нэрлээд байгаа. Таны хэлж байгаа агуулга үнэн л дээ. Үндсэндээ үзэл бодлоо илэрхийлээд эрхээ эдлээд явж байгаа бол энэ жагсаал, цуглаан. Тэр агуулгыг давах юм бол харин нэр томъёо нь юу байх вэ л гэж ингэж ойлгогдож байна шүү дээ. Бид энийгээ жагсаал, цуглаан гэдгээр нь авсан. Тэгэхдээ хууль бус л гэж ангилж байгаа юм. Энэ бол яг Монгол Улсын Үндсэн хууль болоод бусад хуулиар зохицуулагдсан харилцаа, хэм хэмжээг давлаа. Тэгэхээр энэ хууль бус үйл ажиллагаа шүү гэж яаж ангилах вэ гээд. Тэгээд энэнийхээ санаа нь юу вэ гэхлээр бид нар энэ хууль бус гэдэг зүйлээ бас нэлээн сайн тодорхойлохгүй бол эргээд яг таны хэлдэгчлэн угаасаа байсан, угаасаа эдэлж байгаа тэр эрх чөлөөг нь ямарваа хууль бус үндэслэлээр хязгаарлах үндэслэл болох юм биш биз дээ гэдэг зүйл дээр бид нар бас нэлээн анхаарч л энэ дээр оруулсан байгаа.

Д.Цогтбаатар: Баярлалаа. Ингээд гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Одоо хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү.

Эрдэнэболд гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье. Баасанжаргал гишүүнийг оруулаарай.

П.Сайнзориг: Баярлалаа. Ямар ч байсан жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байна. Ажлын хэсэг гаргаад нэлээн сайтар ажиллах ёстой. Ажлын хэсгийг Хууль зүйн байнгын хорооны гишүүдээс толгойлж ажиллаасай гэж хүсэж байгаа. Улсын Их Хурал дээр бас Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах ажлын хэсэг ажиллаад байгаа. Тэгэхдээ яг боловсруулах ажлын

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

хэсэг энэ орж ирж байгаа хуулийг бас Их Хурлын чуулганд бас хуралдаанд бэлтгэх ажлын хэсэг 2 тусдаа гэж л ойлгож байгаа. Тэгээд энийгээ бас даргын хэргийн Даргын дэргэдэх зөвлөл дээр бас ярилцаж, Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлыг яг Хууль зүйн байнгын хорооны гишүүд нь бас ахалдаг оролцдог энэ бас бололцоог нь бас Цогтбаатар даргыг хангаж өгөхийг бас хүсье гэж үзэж байна.

Би асуулт асууя гэж бодож байсан. Тэгэхдээ энэ хуулийн төслийг бас Хууль зүй, дотоод хэргийн яаман дээр бас драфтыг нь анх босгож байсан хүний хувьд бас их асуугаад байх юм алга. Бас бага зэрэг өөрчлөлтүүд байна. Ер нь ихэнх оронд жагсаал, цуглаан хийх журмын гэдэг юм уу, эрх чөлөөний гээд их ганган нэр өгөхөөсөө илүүтэйгээр олон нийтийн газар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тухай хууль гэж л байдаг юм байна лээ. Энэ дээр яаж зохистойгоор энэ үзэл бодлоо илэрхийлэх вэ? Илэрхийлэх арга хэлбэрийн хамгийн анхдагч хувилбар тэр эссембли/assembly/ буюу цуглаан. Цуглаан нь өөрөө үргэлжлээд жагсаалын хэлбэртэй байж болно, магадгүй ажлын багаж хэрэгслээ тавьж хийж болно гээд ийм юмнууд байдаг юм байна лээ.

Гэтэл манай нөгөө Үндсэн хуулиасаа аваачаад жагсаал, цуглаан гээд энэ хоршил үгийг аваачаад хийснээсээ болоод цуглааны нэг төрөл болох жагсаал дээрээ бид нар ач холбогдол өгөөд байгаа. Уг нь энэ Цуглааны тухай хууль байхгүй юу цуглаан. Ийм зүйлүүд байгаа. Тэгээд энэ дээр олон нийтийн газар үзэл бодлоо илэрхийлэх эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний гэдэг юм уу ерөнхий байдлаараа бас нэр томъёог бас хуулийг өөрчлөх асуудлыг бас ажлын хэсэг гарсан тохиолдолд бас анхаарч үзээч гэж байгаа юм.

Ерөөсөө энэ хуулийн гол амин сүнс нь олон нийтийн аюулгүй байдлыг яаж хангах вэ гэдэг дээр л чиглээсэй гэж хүсэж байгаа юм. Улс төрийн тэр эрх чөлөөгөө эдлэхдээ зарим хэсгийг эдэлж болно. Тэдгээр улс төрийн эрх, эрх чөлөөгөө эдэлж байгаа хүмүүсээс гадна яг энэний хүрээлэл дунд байгаа энэний эффектэд өртөж болох олон нийтийг хэрхэн яаж хамгаалах вэ гэдэг зургийг л том зургаасаа хараасай. Энэ олон нийтийн аюулгүй байдлыг хангахдаа хууль сахиулах байгууллагууд нь юу хийх юм, Хүний эрхийн Үндэсний комисс нь юу хийх юм, орон нутгийн түвшинд юу хийх юм бэ гэдэг зүйлийг бас тодорхой болгох. Хэн, юуг хариуцахаа бас тодорхой болгох л байгаа юм.

Тэгээд би энэ дээр нэг зүйл байгаа. Ер нь яг энэ хуулийн дагуу явагдаж байгаа жагсаал, цуглаан эмх замбараагүй байдал руу орох магадлал бас байдаг. Энэ тохиолдолд ямар шийдвэрээр, хэний шийдвэрээр дараагийн алхам буюу онц байдал руу шилжих энэ завсарт нь төрийн байгууллагуудын хэрхэн шийдвэр гаргах болон үйл ажиллагааны процесс тодорхой болох ёстой.

Дээрээс нь ямар ямар төрийн байгууллагууд эрх, үүрэгтэй оролцох вэ гэдгийг ойлгох ёстой. Манайхан аливаа нийгэмд үүсэж байгаа эмх замбараагүй байдлыг яахдаа мөрдөстэй бүх албыг татан оролцуулах гээд байдаг юм.

Гэтэл хууль сахиулах албаны үйл ажиллагаа дээр батлан хамгаалах салбарын мөрдөстэй албан хаагчид оролцуулж болдоггүй байхгүй юу. Гэтэл энэ түвшинд зохицуулалт хийдэг хүмүүс энэ салбарыг татан оролцуулж ирэх болзол хайгаад байдаг. Энэ өөрөө ороод ирэх юм бол жагсаал, цуглаан ч буюу батлан хамгаалах салбарын ажилчид ороод ирвэл хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг болж хувирдаг. Өөрөөр хэлэх юм бол Батлан хамгаалах яам гэдэг бол гаднаас ирж

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

байгаа аюулаас иргэдээ хамгаалдаг хүчин. Дотооддоо ерөөсөө юманд оролцож болдоггүй.

Тийм учраас энэ дээр ерөөсөө аюулгүй байдлыг хангах болон бусад бүхий л шийдвэрүүдээр энэ батлан хамгаалах салбарын хүмүүсийг татан оролцуулж ирнэ гэдэг энэ хандлагууд зарим журмууд дээр байгаа. Энэ хууль дээр биш боловч Жагсаал, цуглааны хуулиас хэтрээд онц байдал руу шилжих энэ завсрын үеийн дүрэм, журмууд дээр энэ асуудлууд байдаг байхгүй юу.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг гүйцээгээд өгье.

П.Сайнзориг: Энэ дээр анхаарах ёстой. Тэгээд өдрийн цагаар жагсаал, цуглааныг хийдэг соёл руу орох ёстой. Эцэст нь энэ Улсын Их Хурлын Тамгын газрын хууль зүйн дүгнэлтийг жишиг зөв тогтооё. Энэ хууль зүйн дүгнэлт чинь бусад орны парламентын жишгээр ийм техникийн саналууд руу ордоггүй байхгүй юу. Бүрдүүлбэр нь байна уу, дээрээс нь энэ шинэчилсэн найруулга хэлбэрээр боловсруулах ёстой байж уу, эсвэл энэ тусгасан асуудлууд нь нэмэлт, өөрчлөлтийн хэмжээнд байна уу? Үндсэн хуулийнхаа үзэл санааны хүрээндээ органик хууль байхаар байж уу, эсвэл ердийн хуулиар орж ирэх байж уу гэдэг байдаг. Даанч манайд энэ хуулийн ангилал нь байдаггүй, батлах квотоо шийдээгүй учраас ийм зүйлүүд дээр дүгнэлт гаргадаг болохоос биш нэг байгууллагаасаа нөгөө байгууллагадаа өгч байгаа санал шиг ийм мэтгэлцээн буюу хууль тогтоогчийн эрх рүү халдаж ингэж дүгнэлт гаргадгаа манай Улсын Их Хурлын Тамгын газар болих хэрэгтэй. Энэ 2 дахиа, 3 дахиа тохиолдож байна шүү. Энэ юун дээр ингээд зөв, буруу янз янзын юм бичээд байдгаа болих хэрэгтэй. Энэ хэлбэр, болоод агуулгын.../минут дуусав./

Д.Цогтбаатар: Гүйцээж микрофондоо яриулах уу? Соронзонболд гишүүний микрофоныг өгье.

Л.Соронзонболд: Байнгын хорооны гишүүдийн өдрийн мэндийг хүргэе. Энэ Улсын Их Хурлын Тамгын газраас ирүүлсэн энэ хууль зүйн дүгнэлтээр энэ хувийн өмчийн газар дээр жагсаал, цуглаан байгуулах тухай асуудал дээр тухайн өмчлөгчийн зөвшөөрлийг авах тухай асуудал тусгагдах ёстой гэдэг энэ бас зөв шаардлага байна гэж би бодож байгаа. Тийм учраас энэ хуулийн төсөл дээр хэрвээ ажлын хэсэг ойлгодог энэ дээр анхаарч ажиллах ёстой юм болов уу гэж бодож байна.

Хоёрдугаарт нэг байршилд, газарт олон зэрэг жагсаал, цуглаан зохион байгуулах зөвшөөрөл олговол яах вэ гэдэг бас асуудлыг бас энэ тухайн ажлын хэсэг маань бас анхаарч үзэх ёстой байх.

Жишээлбэл, Сүхбаатарын талбайг 4 талд нь зэрэг 4 жагсаал, цуглаан зохион байгуулаад байвал яах вэ, зөвшөөрөл өгчихвөл яах вэ, тийм тохиолдол байвал яах вэ гээд тиймэрхүү асуудлууд дээр бас анхаарах ёстой болов уу гэж.

Гуравдугаарт энэ жагсаал, цуглаан зохион байгуулж байгаа этгээдэд 9.2 дээр тухайн жагсаал, цуглааныг сошиал орчинд сурталчилж, уриалж ингэдэг улсууд их олон байдаг. Тэр улсуудыг зохион байгуулагчид оруулж тооцох уу гээд иймэрхүү асуудлуудыг бас ажлын хэсэг ажиллах бол анхаарах ёстой болов уу гэж бодож байна.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Д.Цогтбаатар: Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

Х.Баасанжаргал: Би Алтангэрэл сайдын хийсэн сая нэг мэдэгдэл гэх юм уу тэр зүйлтэй холбоотой бас байр сууриа илэрхийлэх нь зөв байх гэж бодож байна. Нөгөө хөгжлийн бодлоготой холбоотой ийм асуудлыг эсэргүүцсэн тохиолдолд энийг ийм төрлийн жагсаал, цуглааныг зохион байгуулахыг хориглоно гэдэг энэ агуулга концепц өөрөө би буруу гэж бодож байгаа. Тийм тийм тэрийг ойлгосон Уянгахишиг гишүүний асуулттай холбоотой гэсэн үг. Тийм. Тэгэхээр улс орны ийм хөгжлийн бодлоготой холбоотой, энэ урантай холбоотой ч гэдэг юм уу ийм зүйл дээр эсэргүүцэл илэрхийлж байгаа хүмүүсийг яах вэ гээд энийг хориглоно гэдэг байж болохгүй. Тийм. Тэгэхээр энэ бол ийм концепцыг манай Хууль зүйн яам битгий оруулж ирээсэй. Тэгж олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлж үзсэн гэдэг нь өөрөө бас буруу гэж би хувьдаа дүгнэж байгаа шүү. Тэгэхээр энийг бид нар бас их болгоомжтой байх ёстой.

Хоёрдугаарт энэ ийм хуулийн төсөл дээр хэд хэдэн газар ийм ийм субъектив байдлаар тайлбарлагдахуйц нийтийн ёс суртахууныг хамгаалах зорилго гэдэгт яг юуг хэлэх юм? Нийтийн ёс суртахууныг? ингээд л КОВИД-той холбоотой гээд л, бид нарт чинь өнгөрсөн 7 сарын 1-тэй холбоотой гээд л олон кэйсүүд байгаа шүү дээ. Тэгэхээр энийг яаж л бол яаж тайлбарлахуйц ийм субъектив байдлаар тайлбарлагдахуйц ийм нэр томьёо, агуулгууд хэд хэдэн газар орж ирж байгаа нь өөрөө нөгөө санаа зовоохуйц хэдийгээр нэр нь, агуулга нь, үзэл баримтлал нь ингээд зөв боловч яг доторх деталь яг ийм заалтуудыг харахаар ялт ч үгүй ийм санаа зовоохуйц ийм заалтууд байгаа учраас бас яг гишүүдийн хувьд байр сууриа илэрхийлж байгаа байх гэж бодож байна.

Дээрээс нь нэмээд олон нийтийн эрх ашиг, нийтийн эрх ашгийг хамгаалахаас гадна би энэ дээр жагсагчдыг бид нар хамгаалах ёстой гэж харж байгаа юм. Жагсагчдыг. Жагсаал үзэл бодлоо илэрхийлж байгаа хүмүүс аюулгүй, ямар нэгэн асуудалгүй, ямар нэгэн хязгаарлалтгүйгээр энэ жагсаал, цуглаан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг л бид нар илүү хангах энэ баталгаа гэж хармаар байгаа юм. Тэгэхгүй ингээд иргэдийг хамгаалах, олон нийтийг хамгаалах гээд ийм маш ийм ерөнхий утгаар энэ хуулийн хэд хэдэн зохицуулалтууд орж ирээд байгаа учраас бас зайлшгүй энэ дээр байр сууриа илэрхийлэх ёстой гэж харж байгаа.

Тэгээд дээрээс нь энэ нөгөө хууль зүйн дүгнэлттэй холбоотой би бол ялангуяа олон улсын гэрээ, конвенцод нийцэж байгаа эсэх дээр ийм мэргэжлийн дүгнэлт зайлшгүй гарах ёстой гэж харж байгаа. Энэ аягүй чухал дүгнэлт. Бусад гишүүдэд ч гэсэндээ энэ дээр байр суурь, шийдвэр гаргахад энэ чинь өөрөө аягүй дэмжлэг чухал ийм механизм би хувьдаа орж ирж байгаа гэж харж байгаа. Тэгэхээр энэ дэмжих тохиолдолд энэ үзэл юуны хувьд зарим зохицуулалтууд дагаж ирж байгаа хуулиуд дээр онцгой анхаарах ёстой юмнууд нэлээн хэдэн асуудлууд байгаа гэдгийг зориуд бас тэмдэглэх гэж өнөөдөр сая үг хэлэх цаг авсан шүү. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Энэ сая Эрдэнэболд гишүүн үг хэлэх бас сэдэл өгчихлөө л дөө надад. Тэр нь энэ Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газар огцор гэдэг талбай дээр жагсаал болохын өмнө Дотоодын цэргийн командлаг Чингис энэ жагсаалыг

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

санхүүжүүлсэн юм шиг ийм ноцтой мэдэгдэл олон нийтэд хэлэлцсэн юм. Би бүр гайхаж, цочиж хүлээж авсан. Тэгээд энэ чинь бараг төрийн эргэлт маягийн мэдэгдэл хэлчхэж байгаа байхгүй юу. Нөгөө бусад улс цэргийн эргэлт болдог биз дээ. Африкийн улс орнуудад болдог тийм түвшний мэдээлэл хийчихсэн байхгүй юу. Би бол итгээгүй. Тийм, бас энэ салбарын сайдаар ажиллаж байсан хүний хувьд энэ Чингис гээд тэр генералыг бас зам мөрийг нь бас зах зухаас нь мэдэх хүний хувьд би бол итгээгүй. Тэгэхдээ бас ийм далд, нууц мэдээлэл байдаг л юм байх даа юу болдог юм доо гээд бодоод өнгөрсөн.

Хэрвээ тэр мэдээлэл үнэн бол энэ хүн өдийд цагдан хоригдчихсон, төрийн эргэлт хийх гэсэн гээд л онц ноцтой хэрэг шүү дээ. Энэ чинь бүр 20 жилийн ялтай хэрэг шүү дээ. Ийм хүнд гэмт хэрэгт хүнийг буруутгаад яриад явчихсан. Сайд бол мэдээж бас нөгөө далд, нууц мэдээлэл Хууль зүйн сайд чинь бас танилцдаг хүн биш шүү дээ. Тийм учраас Ерөнхий сайд нь ийм ноцтой мэдэгдэл хийчихээр сайд бол би бас ингээд л тийм байх гээд л шийдвэр гаргасан гэж ингэж ойлгоод байгаа юм.

Тэгэхээр энэ дотор би юу хэлэх гээд байна вэ гэхээр энэ жагсаалыг саармагжуулах зорилгоор ийм улс төрийн зорилготой ийм мэдээлэл хийчихсэн тэгээд тэрийгээ нотлоод чадахгүй ингээд болсон яах ёстой юм гэдэг юмыг хүртэл бараг арай хууль бичих ёстой юм биш байгаа даа гээд сая гэнэт энэ Эрдэнэболд гишүүн хөндөнгүүт гэнэт бодоод явчихгүй юу. Тийм, тэгээд энэ чинь генерал хүний бас зам мөр байна, нэр төр байна, үр хүүхэд нь байна. Тийм, тэгээд энэ чинь энэ цагдаагийн байгууллагын дарга байсан хүн шүү дээ. Би дотроо юу гэж хардсан гэхээр Чингис генерал Халтмаагийн Баттулга гэдэг хүнийг эрүүгийн хэрэг үүсгэж баривчлах бодитой үйлдэл хийсэн хуулийн байгууллагын цорын ганц дарга гэж харж явдаг юм. Энэ Баянгол зочид буудалд Чингис даргын үеүд байхгүй юу энэ үйл явдал. Тэгэхээр би энэ улс төрийн өшөө авсан гэж ойлгож байгаа. Энийг далимдуулж энэ хүнээс. Энэ бол миний улс төрийн хардлага.

Тийм учраас энэ хууль сахиулах байгууллагын энэ албан тушаалтнуудыг энэ улс төрчид бие биеэсээ өшөө авах ийм хэрэгсэл болгож юм битгий гараасай гэж бодож байгаа. Хэрвээ Ерөнхий сайд тийм түвшний мэдээлэл байгаа бол тэр хүн гүйцэтгэх буюу улсын нууц задалсан хэрэгт орно. Яг юу болчихсон юм, юу яриад байгаа юм гэдэг тийм мэдээлэл байгаа шүү дээ. Тэгээд тэрийгээ олон нийтэд ярьсан бол улсын нууц задлах гэмт хэрэг энэ нөгөө талд нь. Эсвэл тэр хүн ял авах ёстой. Тэгээд ийм ойлгомжгүй байдал битгий гаргаасай гэж бас бодож байгаа юм.

Д.Цогтбаатар: Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье.

С.Эрдэнэболд: Хоёр агуулга. Нэгд нь болохлоор энэ НҮБ-ын түвшинд ч гэсэн яриад байгаа 1 зүйл болохлоор дэлхий дахинд энэ хөгжлийн хөтөлбөрүүд, хууль бол хангалттай байгаад байна. Гагцхүү үүнийг хэрэгжүүлэх буюу импелментэйшн/implementation/ хийдэг байдал л хамгийн чухал байна гэж. Манай улсад ч гэсэн маш олон төрлийн л хуулиуд байгаад байдаг. Өнөөдөр бид нар цаасан дээр аягүй гоё гоё хуулиуд бичдэг хэр нь яг бодит амьдрал дээр хувь хүний дур зорго, субъектив хандлага тэн дээр нь гишгэлээд л яваад байгаа. Бид нар энийг ингээд л ажиглаад л харж байгаа.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

Тэгэхээр энэ жагсаал, цуглаантай холбоотой асуудал мэдээж энэ эрх чөлөөний хууль гээд гоё тийм гэгээлэг нэртэй ч гэсэн өнөөдрийн яг энэ бодит байдлыг харахаар дийлэнх жагсаал ихэнх нь дандаа улс төрийн найруулгатай бөгөөд улс төрчдийн Пи Ар-ын жүжгийн нэг хэсэг, тавилттай, өрнөлтэй ийм зүйл болчихсон байгаа. Яг жишээлбэл залуучууд органикаараа буюу яг өөрсдийн итгэл үнэмшил дээр талбай дээр гараад юм хийх гэнгүүт нь түрүүн Номинчимэг гишүүний хэлдэг шиг булаалгах буюу тэнд нь улс төрийн өрсөлдөгч нар тэр тайзыг авах ийм л зүйл болчихоод байгаа юм. Тэр Монголын баримт шалгах төвөөс сая нэг мэдээлэл хийсэн байх. Энэ Эм Эф Си Си цэг mn/mfsc.mn/ гээд энэ Монголын баримт шалгах төвийн веб сайт байгаа юм. Энэ дээр бол аягүй ноцтой ноцтой зүйлүүд хэлж байгаа юм.

Юу гэхлээр Монголд болж байгаа энэ жишээлбэл ураны асуудал дээр анхдагч мэдээнүүд хаанаас гараад, түүнийг нь яаж идэвхжүүлээд иргэд, олон нийтийг төөрөгдүүлээд, айдас хүйдэст автуулаад, улмаар энэ нь бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшинд маш том гажуудлын нөлөө эффект өгөөд байгааг харуулсан. Энэ бол гадаадын гадаадын шүү нэг улсын зохион байгуулалттай үйл ажиллагаа байна гэдгийг энэ баримт шалгах төвөөс хэвлэлийн хурал хийгээд зарлаад байгаа. Маш ноцтой, нухацтай. Ямар ямар аккаунт, хаягуудаас яаж яаж зохион байгуулаад байгаа гэж.

Тэгэхээр одоо энэ талбай дээр ч байна, хаана ч байна болж байгаа энэ жагсаал цуглануудын дийлэнх нь бол энэ төрлийн түрүүний Энхбаяр гишүүний хэлдэг шиг мэргэжлийн жагсагчид бөгөөд тэдгээр нь тэгээд цаагуураа ямар гэрээ, контракт байдаг юм ингээд хийдэг болчихсон. Монголд байгаа хөгжлийн сайн сайхан зүйл рүү хар будаг цацдаг, хүний нэр төр, алдар хүндэд эрээ цээргүй халддаг, бие махбодод нь халддаг ийм зүй тогтол болчихсон байгаа.

Тэгэхлээр нэг талдаа бид нар нөгөө жагсаал, цуглаан зохион байгуулах эрх чөлөөний асуудал ярьж байгаа ч гэсэн нөгөө талдаа бас яг ингээд бусдын эрхийг ноцтойгоор, бусдын эрхэнд ноцтойгоор халдана гэдэг нь өөрөө эрх чөлөө биш шүү гэдэг ойлголтыг бас өгөх ёстой. Энэ чинь өөрөө эрх зүйт нийгэм гэдэг чинь хуульт нийгэм гэсэн үг шүү дээ. Тэгэхээр энийгээ ингээд хамт давхар өгч яваач. Тэр утгаар түрүүн сайдаас асуугаад байдаг нь тэр иргэдийн санаа бодол ямар байсан юм бэ, тэрийг яаж тусгасан юм бэ гэдэг асуулт байсан шүү.

Төгсгөлд нь хэлэхэд бол тэр симуляцыг бол их сайн хийгээгүй гэж ойлголоо. Тэгэхээр энэ дээр ч гэсэн Хууль зүй, дотоод хэргийн яам болон холбогдох газрууд бас энэ симуляц хиймээр байгаа юм. Бид энэ эдийн засгийн асуудал дээр, мөн энэ хуулийн хэрэгжилтийн асуудал дээр симуляцуудыг сайн хийдэг баймаар байгаа юм.

Өөрөөр хэлбэл, хэмжиж чадвал хянаж чадна. Хянаж чадвал удирдаж чадна гэгчээр бид ямар асуудал, бэрхшээлийг ямар зарчмаар, ямар механизмаар шийдвэрлээд улмаар ямар бэрхшээлүүдийг бид нар засах гээд байгаа вэ гэсэн хэм хэмжээний тухай яригдаад байгаа шүү дээ. Тэр үүднээсээ бол энэ дээр симуляцыг заавал хийдэг байгаасай. Манай хуулиуд аягүй гоё романтик орж ирдэг, 14 мега төсөл эд нар гээд аягүй романтик орж ирдэг хэр нь яг энэ симуляц буюу энэ эдийн засаг, нийгэм, улс төрд нөлөөлөх нөлөөлөл дээр нь очоод

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

судалгаа хангалттай биш гацчихдаг ийм байгаад байгаа шүү гэдэг санааг хэлье. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Би ганц, хоёр санаа хэлнэ. Ер нь энэ үзэл, агуулгатай хууль орж ирж байгаа маш зөв. Хуулийн жижигхэн техник ашиглаад зөвшөөрөл гэдэг үг хэрэглэхгүйгээр зөвшөөрдөг арга хэрэглэнэ гэдэг ард түмнийг залилж байгаа хэрэг. Ийм юмыг зогсоох хэрэгтэй. Яагаад гэвэл Үндсэн хуулиараа энэ үгээ хэлэх эрх чөлөө гэдэг чинь Үндсэн хуулиараа олгогдсон. Энэ яг хүмүүс ингээд тэр болгон юутай бусад нөгөө ямар хувь эрх, суурь эрх вэ гэхлээр амьдрах эрх суурь эрх, амьдрах эрхээ Монгол Улсын иргэнд төрөөс зөвшөөрөл авдаггүй. Би амьд баймаар байна гэж зөвшөөрөл авахгүй. Энэ цаанаас нь өгөгдчихсөн зүйл. Өмчтэй байх эрх нь энэ шинэ Үндсэн хуулиар чинь цаанаасаа олгогдсон. Би өмчтэй байж болох уу гэж төрөөс зөвшөөрөл авдаггүй. Үгээ хэлэх эрх чөлөө бас яг адилхан.

Өөрөөр хэлбэл, хүний фундаментал шинж чанартай суурь эрхүүд дээр төрөөс зөвшөөрөл авна гэдэг ойлголт ерөөсөө угаасаа байж болохгүй. Юун төр зөвшөөрөл өгөх байтугай төр чинь өөрөө ард түмний засаглах эрхийн зөвшөөрлөөр өөрөө оршин тогтнож байгаа байхгүй юу. Өөрөө ард түмний зөвшөөрлөөр оршин тогтнож байж ард түмэнд дараа нь үгээ хэлэх эрхийг нь зөвшөөрнө гээд байдаг чинь өөрөө утгагүй. Эс үгүй бол ард түмэн өөрөө өөртөө үгээ хэлэх эрхийг зөвшөөрөх гээд байгаа юм уу? Тийм учраас энэ зөвшөөрөх ойлголт угаасаа Үндсэн хуульдаа цаанаасаа байж болохгүй. Ямар нэгэн арга, хэлбэрээр зальдаад, гоё үгээр илэрхийлээд, гэхдээ эцсийн дүндээ хэрэглэгдэхдээ зөвшөөрөл маягаар байж болохгүй гэдэг чинь эндээс л ургаж гараад байгаа юм.

Тийм учраас энэ амьдрах эрх, үгээ хэлэх эрх, хувийн өмчтэй байх эрх эд нар гэдэг чинь суурь шинж чанартай эрх учраас энд тэр зөвшөөрлийн тухай ойлголт байхгүй. Энийг арилгах гэж орж ирж байгаа нь маш зөв өө. Тэгээд энэ дээр би нэг зүйлийг гэхдээ хэлмээр байна. Энэ хувийн өмчийн талаар би яагаад энд дурдаад байна гэхлээр Алтангэрэл сайдаа ажлын хэсэг манайхан байгуулахдаа нэг юм анхаараарай. Энэ чинь хувийн өмч дээр жагсаж болохоор санаа ороод ирчихсэн яваад байна. Та нар АНУ-д хүний өмч рүү яваад орвол буудах эрхтэй шүү дээ. Өөрийгөө, амиа хамгаалж байгаатай адилхан хамгаалагддаг эрх байхгүй юу. Монгол Улс чинь Ардчилсан Бүгд Найрамдах Улс юм бол Ардчилсан Бүгд Найрамдах Улсад ийм л байдаг. Тэгэхлээр энэ дээр энэ заалтыг манайхан маш нарийн анхаарч яахгүй бол жагсаал, цуглааныг хувийн өмч дээр хийж болохоор юм шиг оруулж ирнэ гэдэг өөрөө ноцтой Үндсэн хуулийн зөрчлийн тэгээд Хууль зүйн яамнаасаа Засгийн газраараа оруулж ирж байгаад ийм юм оруулаад ирж байна гэдэг чинь байж болохгүй зүйл шүү. Энийгээ та нар харж, ажлын хэсэг энийг анхаарах ёстой.

Энэ дээр тэгэхлээр энэ юуг анхаарахын зэрэгцээгээр энэ нэр томъёоны зөрчлүүдээ би түрүүн Алтангэрэл сайд хэллээ тээ? Энэ юмнуудаа харахгүй бол гоё юм бодож байгаа санаандгүйгээр аягүй их юм хязгаарлачихсан байх вий. Тэгэхлээр энэ тэгж, нэгэнт угаасаа угаасаа энэ хууль өөрөө хязгаарлалт тогтоож зохицуулах гэж байгаа хууль байхгүй юу. Тэгэхлээр энийг минимум түвшинд л байлгах тухай ойлголт явна уу гэхээс энэ хууль чинь эцсийн дүндээ эргээд нөгөө Үндсэн хуулиар олгогдсон суурь эрхийг баталгаажуулах тухай хууль байгаа шүү. Энийгээ та нар маань бодож үзээрэй гэж хэлмээр байна.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа. Асуулт асууж, хариулт авч дууссан. Одоо үг хэлж дууслаа.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35.11-д Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар ил санал хураалт явуулна гэж заасны дагуу санал хураалт явуулна.

1. Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

75 хувиар санал дэмжигдлээ.

Манайхан байж байгаарай. Болоогүй байгаа шүү. Энд хэдэн санал хураалт байгаа.

2. Хууль хүчин, саяынх ингээд 75 хувиар дэмжигдсэн шүү.

2. Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

66.7 хувиар санал дэмжигдлээ.

3. Дайны байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Миний саналыг дэмжсэнд тооцоорой. Би дэмжсэн. Ороогүй байна. 3-ыг сая уншихсан тээ? Дайны байдлын тухай.

Дотоодын цэргийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

75 хувиар санал дэмжигдлээ.

5 дугаар санал. Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

75 хувиар санал дэмжигдлээ.

6. Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

66.7 хувиар санал дэмжигдлээ.

Санал хураалтын дүнг ингээд танилцуулж дууслаа.

Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Тэмүүжин гишүүн танилцуулчих уу? Тэмүүжин гишүүн танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүдэд баярлалаа.

17.16 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР